

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-35

1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	6-26
2.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	26-32
3.Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай	32-35

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар сарын 25-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт, Т.Доржханд;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Санхүү, эдийн засгийн газрын дарга Ж.Бямбасүрэн, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Энхманлай, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга В.Жавзан, мөн зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Төсвийн ерөнхий нягтлан бодогч Н.Болортуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын дэд дарга Ц.Батбаатар, Санхүү, хангамжийн үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Наранцэцэг, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлан зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд 15 цаг 37 минутаас 16 цаг 25 минутад хуралдааныг даргалав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, А.Адъяасүрэн, С.Амарсайхан, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Байнгын хорооны дарга Н.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Цахилгааны саатлын улмаас 16 цаг 10 минутад “Их засаг” танхимд шилжиж, хуралдааныг үргэлжлүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн 16 цаг 25 минутаас 16 цаг 50 минутад хуралдааныг даргалав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нар үг хэлэв.

Н.Энхболд: Засгийн газраас оруулж ирсэн төсвийн төслөөс зөрсөн зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 10
Бүгд: 12
16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Санхүү, эдийн засгийн газрын дарга Ж.Бямбасүрэн, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Ажлын албаны дарга В.Жавзан,

Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Төсвийн ерөнхий нягтлан бодогч Н.Болортуяа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Наранцэцэг, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Байнгын хорооны дарга Н.Энхболд үг хэлэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, Байнгын хорооны дарга Н.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Н.Энхболд: Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт 57.18.Төсвийн байгууллагын нягтлан бодогчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг тухайн салбарын төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлтэй адил байхаар тогтоож болно гэсэн заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэв.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Наранцэцэг, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн нэрийг дэвшүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийг Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргаар сонгох нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Н.Энхболд тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 21 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 79.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим,
15 цаг 20 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Тогтохсүрэн: Төрийн
байгуулалтын байнгын хорооны
гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралд 19 гишүүнээс одоогийн байдлаар 10 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Улсын Их Хурлын гишүүн Амгалан, Улсын Их Хурлын гишүүн Ганболд, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Улсын Их Хурлын дарга Занданшатар, Тогтохсүрэн гишүүн нарын 10 гишүүн хүрэлцэн ирж, хурлын ирц хуралдах шаардлагыг бүрэн хангаж байгаа тул 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны ажиллагаа нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хурлаар 3 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт, 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 24 оны төсвийн тухай төслүүд. Засгийн газар 23 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг хийнэ. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

2 дугаар асуудал нь, Төрийн албаны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газар 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг явуулна. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

3 дугаарт нь, Сонгогчийн нэрсийн жагсаалт бүртгэлийн дэд хорооны даргыг сонгох тухай асуудал гэсэн 3 асуудлыг өнөөдөр бид нар хэлэлцэн шийдвэрлэхээр санал оруулж байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Эхлээд нэг тайлбар хийе. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-д заасны дагуу төсвийн болон бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд нам, эвслийн бүлэг, төсвийн төслийг хэлэлцэнэ. Мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны 70 дугаар зүйлийн 70.2-т санхүү төсвийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг, Монгол улсын ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтээ тус тус танилцуулна гэж байгаа. Энэ чинь Жавхлан танилцуулга хийдэг юм уу, хийдэг юм

байлгүй дээ энэ чинь. Уул нь 2 дугаар хэлэлцүүлэг хийдэг юм уу?

Бид чинь энэ нөгөө манай Байнгын хороо чинь нэг хэдэн байгууллагын гишүүд ээ, хэдэн байгууллагын төсөвтэй холбоотой юм ярина шүү дээ. Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол Улсын Их Хурлын даргын багц, Ерөнхий сайдын багц, Шадар сайдын багц, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн багц, Сонгуулийн ерөнхий хорооны багц, Төрийн албаны зөвлөлийн багц гэсэн ийм байгууллагуудын төсвийн төслийг бид нар хэлэлцдэг юм.

Тийм учраас манайхан гол холбогдолтой асуудал нь үүнийг хэлэлцэх нь ээ гэж ингэж ойлгоорой.

Би өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя. Сангийн сайд Жавхлан, Мөнгөнчимэг Сангийн дэд сайд. Орж ирсэн хүмүүс босоод байгаарай. Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга Содбаатар, Содбаатар байхгүй байна. Ерөнхийлөгчийн Тамгын газраас хэн байна? Төсвийн ерөнхийлөн төсвийн шууд захирагч нь хэн юм. Энх-Амгалан биз дээ? Энх-Амгалан билүү? Энх-Амгалан дуудаарай. Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд дарга Үнэнбат, Монгол улсын ерөнхий аудитор Занданбат, Занданбат даргыг дуудаарай. Төрийн албаны зөвлөлийн дарга Баатарзориг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Баасандорж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ариунболд, Шадар сайдын ажлын албаны дарга Мөнх-Оргил байна уу? Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярбат байна уу? Лхагвасүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамжийн үйлчилгээний хэлтсийн дарга, Бямбасүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх

газрын Санхүү эдийн засгийн газрын дарга, Хэрэг эрхлэх газар чинь ямар том газартай болсон юм бэ, дотроо. Сангийн яам шиг л болсон байх чинь. Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга байна уу? Санжаадорж. Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга дуудаарай заримыг нь. Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Сүх-Очир Сангийн яамны Санхүү бодлогын газрын дарга, Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга, Наранчимэг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч аудит байна уу? Ер нь аудитынхан юун дээр байгаа юм уу? Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга, Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Самбууням товчилсон нэрийг мэдэхгүй байна. Энэ бол аудитын нэг газрын захирал л юм байна. Тэргүүлэх аудитор. Энхболд мөн ялгаагүй тэргүүлэх аудитор, Мөнхцацрал Аудитын удирдлагын менежер, Баярмаа Аудитын менежер, Энхбаатар ахлах аудитор, Сандуйжав ахлах аудитор, Даваадорж ахлах аудитор, Баатарсайхан Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Жавзан Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга, Ч.Бат-Эрдэнэ Төрийн албаны зөвлөлийн Хянан шалгах газрын дарга, Болортуяа Төрийн албаны зөвлөлийн ерөнхий нягтлан бодогч, Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Болормаа Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын

газрын ахлах шинжээч, Энхтуяа Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Хууль, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Уранцэцэг Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч, Энхманлай Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Дашням Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Цолмон Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Хангал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Сансармаа Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн, Анар Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын ахлах шинжээч гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна.

Одоо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 2024 оны төсвийн талаарх манай Төрийн байгуулалт байнгын хороонд хамаарагдах байгууллагуудын төсвийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдыг урьж байна. Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улсын эдийн засаг сайжирч, улмаар урт хугацааны

хөгжлийн эхний 10 жилийн зорилт болох шинэ сэргэлтийн бодлого хэрэгжүүлэх боломж бүрдээд байна. Тиймээс шинэ сэргэлтийн бодлогын гол зорилтын нэг болох хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр ирэх 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно. Ирэх 2024 оны төрийн албаны тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх зарим онцлог арга хэмжээг дурдъя.

1. Төрийн албаны тухай хуульд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр орсон өөрчлөлтийн дагуу сум болон нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам 1 удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох, Улаанбаатар хотоос бусад орон нутагт ажиллах төрийн албан хаагч Төрийн албаны тухай хуульд заасан ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан бол хугацаанаас нь өмнө шатлан дэвшүүлэх эрх зүйн өөрчлөлтийг нээх,

3. Инфляц амьжиргааны түвшин, цалин хөлсний дундаж өсөлттэй уялдуулан төрийн албан хаагчдын цалинг 24 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 10 хувиар нэмэгдүүлэх. Өөрөөр хэлбэл 2023 оны 07 сард хийсэн Монгол Улсын төсвийн тодотголоос хойш инфляцын өөрчлөлтийн энэ тодорхой хугацааг өнгөрүүлсний дараа дахин инфляцад идэгдүүлэхгүй байх ийм хугацааны дараа хийх өөрчлөлт юм.

4. Хөдөөгийн сумд ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчдад сар бүр үндсэн цалингийн 40 хувиар, харин аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт ажиллаж байгаа дээрх ангиллын албан хаагчдад сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тус тус тооцож нэмэгдэл олгох,

5. 2024 онд Улсын Их Хурлын болон орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан СЕХ, УБЕГ болон цагдаагийн байгууллагад шаардагдах зардлыг тусгах.

6. Газрын менежменттэй холбоотой чиг үүргийг нэгдсэн бодлогоор төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулах үүднээс газрын харилцаа зөвшөөрлийн асуудлыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх эрх зүйн зохицуулалт хийх зэрэг болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Ирэх 2024 оны төсөв санхүүгийн бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25,3 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 27,4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2,1 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2,8 хувь болж төсвийн тусгай шаардлага хангагдаж байгаа болно.

Иймд ирэх оны төсвийн төсөлд төрийн албыг бэхжүүлэх талаар тусгасан арга хэмжээний танилцаж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Одоо төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар танилцуулгыг Монгол улсын ерөнхий аудитор Занданбат танилцуулна. Энэ юун дээр бодвол танилцуулж байгаа юм байх даа. Байнгын хороод дээр. Тийм байна тийм ээ. Занданбат дарга байхгүй бол. Занданбат дарга ажлын хэсгийн 2 уу. 2 номерын микрофоныг өгье.

Д.Занданбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын

байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хянан шалгахын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг 7 зорилтын хүрээн дээр хянаж үнэлэхэд аудитын зорилго чиглэсэн. Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн гэж дүгнэж байна. Үүнд:

1. Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцаа 2024 онд 40,7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд байна.

2. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289,8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34,2 хувь, нийт зарлага 27 их наяд 360,5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70,8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу

ДНБ-ий 2,8 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

3. Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулахад Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдлаар төлөвлөжээ.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга төвлөрүүлэх орлого 0,2 тэрбум, зардал 29,7 тэрбум, Улсын Их Хурлын дарга 0,1 тэрбум, зардал 131,9 тэрбум, Ерөнхий сайд 600,4 тэрбум орлого төвлөрүүлнэ. 330,2 тэрбум төгрөгийн зарлага, Шадар сайд төвлөрүүлэх орлого 15,6 тэрбум, зардал 280,8 тэрбум, Сонгуулийн ерөнхий хорооны дарга зардал 65,2 тэрбум, Төрийн албаны зөвлөлийн дарга зардал 6,2 тэрбум, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга зардал 19,1 тэрбум, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга зардал 102,2 тэрбум, Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга зардал 56,2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зардлын дүн 2023 оны тодотгосон төсвөөс 16,9 тэрбум төгрөгөөр хасагдаж, 1 их наяд 21,6 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн нь ОУБ-ын гишүүнчлэлийн татвар дахь гадаад валютаар төлөх ханишийн зөрүүний нэмэгдэл, Хөвсгөл нуурыг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгоор тус нуурт живсэн машин, техник татан гаргах үйл ажиллагааны зардал Засгийн газраас 2024 онд нийт албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэх бодлого баримталсантай холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, зорилттой нийцэж буй хэдий ч Монгол Улсын 2024 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнээс ЗГХЭГ нь дараах 3 арга хэмжээг тусгаагүй байна.

Төрөөс бизнесийн үйл ажиллагаанд хийх давхардсан хянан шалгалтыг бууруулах, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2024 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны төсвийн нийт багцад 126,2 тэрбум төгрөгийн 36 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 110,4 тэрбум төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ тусгагдсан 35,7 тэрбум төгрөгийн 14 төсөл, арга хэмжээ тусгаадаагүй байна.

Үр дүнд чиглэсэн төсөвлөлтийн аргыг улсын болон орон нутаг мөн салбарын төсөвлөлтөд хэрэгжүүлснээс бий болох үр өгөөж, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор хэмжих үзүүлэлтийг тодорхой болгож, хүрэх үр дүнг богино, дунд хугацаагаар тодорхойлж үйл ажиллагааг хэмжсэнээр төсвийн зардлын ашиглалт, үр өгөөж нэмэгдэж, төлөвлөсөн хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжтой болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дараах дүгнэлтийг танилцуулж байна.

1. Төсвийн төсөлд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, татварын орлого зэргийг өөдрөгөөр төсөөлсөн нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл үүсвэл төсөвт тодотгол хийх нөхцөлд хүргэж болзошгүй байна.

2. Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүйгээс төсвийн орлого, төсвийн зорилго хангагдах, эсэхийг үнэлэх боломжгүй байна.

3. Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэх, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан эдийн засгийн бодит үр өгөөжийн тооцоо судалгаа хийх аргачлалыг боловсруулан баталж, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.11 дэх заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4. Гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн алдагдлын тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна.

5. Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд магадлал хийгдэж байгаа 21, нэг маягаар болон жишиг магадлалтай 153 төсөл, арга хэмжээг тус тус тусгасан байна. Барилга, байгууламжийн зураг төсөл, магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах, захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, улсын комисс, барилга байгууламжийг хүлээн

авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан субъектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд дараах асуудлыг толилуулж байна.

Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт бүрэн тусгуулахад анхаарах. Өмнөх аудитаар толилуулсан төсвийн төслийг үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг үнэлж, дүгнэх аргачлал, шалгуур үзүүлэлтийг холбогдох хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгах тухай өгсөн асуудлыг энэ жил дахин толилуулж байгааг анхаарахыг хүсэж байна.

Монгол Улсын Засгийн газар дараа оны төсвийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихдаа Төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Монгол Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихдаа төсвийн төсөл боловсруулах тухайн үе дэх хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх, улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх, улсын төсвөөс санхүүжүүлж, хэрэгжүүлэхээр Төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй шалтгаан, нөхцөлд нарийвчилсан судалгаа дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах, барилга байгууламжид зураг

төсөл, магадлал хийх ажлыг зохион байгуулах, худалдан авах үйл ажиллагаа, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах гэрээний хэрэгжилтийг хангуулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, Улсын комисс хүлээн авах үйл ажиллагаанд субъектив сөрөг нөлөөлөлгүй байлгах тодорхой нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах, хөгжлийн бодлогод нийцүүлсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж чадавхыг нь сайжруулах зэрэг зөвлөмжийг өгч байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Хууль санаачлагчаас болоод Ерөнхий аудиторын танилцуулгаас асуух гишүүд байвал нэрээ өгье. Жаргалмаа гишүүнээр тасаллаа. Ганболд гишүүн асууя.

Г.Ганболд: Орж ирсэн байгууллагуудын төсөв дээрээс нэг их асуугаад байх юм алга. Зүгээр хөрөнгө оруулалтын энэ ковидтой холбоотой нэг үнийн өсөлтүүд гээд нэг юмнууд орж ирээд яваад байдаг. Энэ өөрөө жаахан утгагүй болж эхэлж байна л даа. Жишээлбэл бид нар чинь энэ багийн төвийн барилгыг л ер нь тэрбум руу дөхүүлж л барьдаг болж байна л даа. Одоо энэ дээр ингээд Ховд аймгийн Буянт сумын Наран хайрхан багийн төвийн барилга өнгөрсөн жил уг нь 200 гаран сая байсан чинь энэ жил бүр 857 сая. Намайг нэг аймгийн Засаг дарга нэг 3 жил гаруйн өмнө байхад нэг 75-100 саяар л багийн төв барьж байсан л даа. Багийн төвийн барилга нэг үсрээд 100 гаран метр квадрат л барилга байгаа. Тэгэхээр 857 сая болсон байна. Багийн

төвийн барилга. Энэ хэдэн метр квадрат барилга байна аа? Яагаад ингээд өнгөрсөн жилээсээ төсөв нь 4 дахин нэмэгдэж байна аа? Тэгэхээр энэ чинь бол өнгөрсөн жил тендерээр ингээд нэг бодвол 200 гаран саяар авчхаад, тэгээд энэ жил үнийн зөрөө гээд л аягүй бол нөгөө төсвийн магадлангаар ороод л ингээд орж ирж байна л даа. Тэгээд энэ бол нэг төрлийн бараг их утгагүй болж хувирч байгаа юм. Бага үнээр тендер авчхаад, сүүлд нь үнийн зөрөө гээд ингээд асар их нэмэгдэж орж ирдэг. Энэ нь төсвийн их том дарамт болж байна. Яг энэ багийн төв дээр нэг тодорхой хариу өгөөдхөөч. Багийн төвөө бид нар тэрбумаар бариад эхлэх юм бол энэ улсын төсөв өөрөө утгагүй болж эхлэх гээд байна. Нэг жишиг рүү орохгүй бол болохгүй.

Яг тэрэнтэй адилхан ингээд энэ иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга гээд сумдад бодвол Тамгын газар болов уу л гэж бодож байна. Сумдын Тамгын газрууд бүтэц орон тоо нь бүгдээрээ адилхан шүү дээ. Нэг Засаг даргатай, нэг орлогчтой, тэгээд л ерөөсөө 13 хүнтэй. Гэтэл ингээд Архангай аймгийн Булган сумын Тамгын газар 6 тэрбум бусад сумдынх нь 2,4 тэрбум. Тэгээд Архангайн Булган сумынхан яах юм 2, 2 дахин 3, 3 дахин том өрөөнд суух юм уу, тэр 13 хүн нь. Тэгээд энийгээ ер нь нэг 1 загварын барилга руу оруулаад Тамгын газрууд нь нэг дотор нь ажиллах хүний тоо нь нэг юм чинь. Бүгд дээр нь ийм адилхан жишигийн барилга барихгүй бол ингээд орж ирсэн тоогоор нь хэдүүлээ ингээд батлаад явах юм бол энэ чинь бас жаахан буруу жишиг рүү орох гээд байна. Энэ Булган сумын барилга гэж бас яг ямар том барилга яагаад ийм бусдаасаа 2, 3 дахин их том өртөгтэй байна аа? Бодвол энэ Тамгын газар болов уу л гэж бодож байна л даа.

3-д нь, энэ СЕХ дээр сая шинэ хууль батлагдсантай холбогдуулаад баахан орон тоо нэмсэн. Энэ төсөв дээр

яг тэр ирэх жилийн нэмэгдэх ажилчдын цалин хөлс юмнууд нь суусан уу. Ийм зүйл л асууя.

Н.Энхболд: Хэн хариулах вэ? Жавхлан сайд. Дараа нь Хэрэг эрхлэхээс хэн байна, тэнд. Баасандорж дарга бэлдэж байгаарай.

Б.Жавхлан: Ганболд гишүүний асуултад хариулъя. Ганболд гишүүн өөрөө сайн санаж байгаа байх. Ноднин энэ төсөвт өртгийг нэм, тэрнийх орхичихлоо, энэнийх үлдчихлээ гээд бид нарыг нэлээн загнаж байсан санаж байна. Тэрнээс хойш Барилга хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төвөөр магадлан хийгдсэн төсөвт өртөг нь нэмэгдсэн бүх төслүүдийг бид нар давхар аудитаар оруулж байгаа. Аудитор орж ирсэн, сая бид нар төсөв өргөн барих хүртэл 09 сарын 29-ний ажлын цаг дуустал аудитаас ирсэн хүлээж байгаад бүх төслүүдийг оруулсан байгаа. Аудитаас дээшээ бид нар дахин аудитлах, магадлах бидэнд эрх мэдэл хаана ч байхгүй байгаа. Одоогоор. Ингээж орж ирсэн төслүүд шүү.

Дээрээс нь тэр төсөвт өртгүүд нь зөрөөтэй байгаа бол би танд хэлэхээс өөр арга байхгүй. Ямар учиртай вэ гэвэл Сангийн яам дээр байдаг системээр орж ирж байгаа төслүүд бол төсвийн эрхэн захирагч нараас, сайд нараас бүх шаардлага нь хангагдаад орж ирж байгаа л төслүүд шүү. Түүн дотор нэг юу гэдэг юм нөгөө нэг хэвийн, нэг нөгөө юуны зургаар гэдэг төсөв, төсөл яамдаас байхгүй. 1 ижил зурагтай гэдэг бол яг гишүүдээс санал орж ирсэн зүйлүүд л дандаа тэгж орж ирдэг. Дандаа тийм төсөл байгаа. Хэрвээ тийм шаардлага тавьж бүгдэд нь ижилхэн тавих хэрэгтэй.

Дээрээс нь цаашидаа ч гэсэндээ нэг ижил хэвийн зургаар гэдэг юм байж болмооргүй болчихоод байгаа юм. Өмнөговь аймагт нэг хэвийн нэг зургаар үзэж барих, өөр аймагт 1 зургаар 1

ижил үзэж барих 2 төсөв нь яг магадлан хийгээд холбоосоо хийсний дараа шал өөр гарч ирдэг. Байгаль орчны үнэлгээ хийнэ, дэд бүтцийг нь хаанаас татах вэ гээд бүр хааш нь харуулж барихаас хүртэл эхлээд төсвүүд нь өөр өөр болоод гараад ирдэг. Нэг ижил зургаар орсон байгаа үзэж барихууд яг тендер зарлах дээрээ тулах юм бол дахиж магадлан хийгдээд холболтууд нь хийгддэг. Дахиад шал өөр төсөв болоод явчихдаг. Тэр төсвүүд нь тэгээд дараа жилийнхээ магадлангаар нэмэгдэж орж ирдэг, төсөв дээр ийм дарамт болоод ингээд яваад байдаг. Харин зүгээр жил ирэх тусам энэ бол ингээд багасаад ингээд явж байгаа. Илүү их яг системээрээ төсвийн эргүүлэн захирагч нараас, яамдаас дамжиж орж ирсэн ийм зураг төсөвтэй, ийм төслүүд нь бол дийлэнх нь байгаа.

Ганболд гишүүн удаа дараа асууж байгаа учраас та чуулган дээр ч гэсэн бас асуусан, асуух эрх байлгүй яах вэ. Тийм учраас би тайлбарыг нь өгч байгаа юм шүү. Яг тэгээд тодорхой төслүүд дээр асуусан зүйлүүд дээр нэмэлт мэдээлэл өгөөдхөөч.

Н.Энхболд: Баасандорж дарга. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга. Тэр 2 сумынх яагаад тийм том зөрөөтэй байна вэ? Бусад сумдаа Ховдын Манхан 6 тэрбум наадуул нь 2,4 тэрбум.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Баасандорж, Ганболд гишүүний асуултад хариулъя. Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга байгууламжтай холбоотой өртөгтэй холбоотой асуулт асуусан. Ялангуяа нийтдээ энэ 24 оны төсөвт дууссанаар 8 аймгийн сумын төв дээр Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга барихаар тусгагдсан байгаа. Сая гишүүний хэлсэн Архангай аймгийн Булган сумын мэдээллийн төв нийт төсөвт өртөг нь 2,4 тэрбум Булган сумынх. Ирэх жил 1,2 тэрбум нь тавигдсан байгаа.

Манай энэ өргөн мэдүүлсэн төсөл дээр би яг өргөн мэдүүлсэн төслөө хараад л яаж байгаа даа. Эндээс нэгтгэл дээр яаж харагдсан юм бол одоо ингээд Иргэдэд үйлчлэх Архангай аймгийн Өндөр-Улаан байгаа. Архангай аймаг дээр. Өшөө Архангай аймаг дээр Цахир сум байгаа юм. Энэ 3 яг адилхан төсөвт өртөг нь 2,4 гэж байгаа юм.

Н.Энхболд: Ийм байна Баасандорж дарга аа. Гишүүдэд тарааж өгсөн материал дээр Архангайн Булган сумынх 5 тэрбум 949,2 сая гээд энэ дээр биччихсэн энэнээс санхүүжих дүн нь тэрбум 784 гээд биччихсэн ийм тоо байна л даа. Энийг тойруулж асуугаад байна. Тэр багийн төв яахаараа тийм 800 сая энэ тэр бараг тэрбум шахуу юм болж байдаг тийм. Ямар багийн төв вэ, хэдэн иргэнтэй багийн төв юм тэр чинь.

Баасандорж дарга. 5 дугаар микрофон, 6 юм уу?

Б.Баасандорж: Энхболд дарга аа, Ганболд гишүүн ээ, яг Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсөл дээр нийтдээ яг 2,4 тэрбумаар ирэх жил санхүүжих төсөв нь 1,2 байгаа. Их Хурлаас нэгтгээд тараасан төслийг бол яг нөгөө Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийг нэгтгэж тарааж байгаа. Тэгэхээр би түүн дээр дүгнэж хэлж мэдэхгүй. Яг Засгийн газраасаа өргөн мэдүүлсэн төсөл яг ийм байгаа шүү гэдгийг танилцуулъя.

Архангай аймаг, өшөө мөн Говь-Алтай аймаг, Говь-Алтай аймаг дээр байгаа Сэлэнгэ аймаг байгаа.

Н.Энхболд: Тэд нарыг харчихсан, тэд нарыг харчихсан. Тэр багийн төвийн асуудлыг хариулаадах. Ямар гээчийн шидтэй тийм том барилга тэнд барих гээд байгаа юм бол 800 сая. Тэрбум шахуу төгрөгөөр.

Энэ Их Хурлын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсийнхэн бас тайлбар

өгөөд яагаад Засгийн газраас 2,4-өөр орж ирсэн юм танай хэлтсээр дамжихаараа 5,9 болоод ороод ирсэн юм тэрийг тайлбарла аа. Тийм. Ганбат дарга 7 номер, 6 юу 6 номер.

Ж.Ганбат: Асуултад хариулъя. Энэ багийн төвийн барилга Ховд Буянт сум гээд Наранхайрхан баг гээд энэ хэрэгжих хугацаа нь гүйцэтгэгч нь Авга ач нар ХХК гээд хэрэгжих хугацаа нь 2020-24 онд гээд, эхлэхдээ энэ 233,9 сая төгрөгөөр эхэлж байсан юм байна. Тэгээд ажлын явц нь 27,3 хувьтай, 2023 онд 200 сая төгрөг батлагдсан боловч санхүүжилтийг нь олгоогүй. 2023 онд энэ одоо 20 онд 250-аар явж байгаад, 2023 онд 860,9 сая төгрөг болж нэмэгдсэн. Энэ нөгөө экспертиз ороод магадалгаа хийгдээд ингээд нэмэгдүүлсэн. Барилгын хөгжлийн төвөөр баталгаажсан дүн нь ингэж нэмэгдсэн юм байна.

2024 оны төсөвт өртгийн тендерийн хэмнэлтээр 3,9 сая төгрөгийг нь бууруулаад 857 сая төгрөгөөр санхүүжих дүнг нь төсөвт өртгийг нь тавиад санхүүжих дүнг нь 423,1 сая төгрөг гэдгээр өргөн барьсан байгаа. Тэгэхээр энэ яах вэ, Барилгын хөгжлийн төвөөр экспертизийн дүгнэлт магадалгаа нь хийгдээд ингэж орж ирсэн. Ийм л төсөвт өртөгтэй юм байна. Аудит энэ дээр нэмэлт тайлбар хэлэх ёстой юм болов уу.

Н.Энхболд: Аудитын байгууллагаас энэ нөгөө магадалгаа хийсэн хүмүүсээс хариулт авъя. 500 саяар жилийн дотор нэмэгдчихдэг ямар төсөв байдаг байна. 1 номерын микрофон, нэрээ албан тушаалтайгаа хэлээд.

Үндэсний ... /цахилгаан тасрав/

Танхимын цахилгаан тасарсан тул “Их засаг” танхимд шилжин үргэлжлүүлэн хуралдав. /16:10/

Д.Тогтохсүрэн: Хуралдаанаа үргэлжлүүлэе. Техникийн саатлаас болоод түр завсарласан. “Г” танхимд хуралдаан үргэлжилж байна.

Сандал авчирч тавиад ажлын хэсгийн гишүүдийг араар тавьж байгаад багтаагаадхаарай. Түрүүчийн нэрс хаана байна. Гараар бичиж авсан хүн байна уу? Гүйцээе. Ганболд гишүүн асууж байна.

Ажлын хэсгийн 2 номерын телефон. Сонгуулийн ерөнхий хороо Дэлгэрнарар дарга.

П.Дэлгэрнарар: Ганболд гишүүний асуултад хариулъя. Манайх сонгуулийн зардал, байгууллагын төсөв 2 нийлээд 65,2 тэрбум төгрөгөөр Сангийн яам хянасан байгаа. Энэ дотор сонгуулийн зардлыг бид нар хянасан зардлаар сонгуулиа бол явуулж болно гэж үзэж байгаа. Байгууллагын төсвөөс 2,1 тэрбум төгрөг хасагдсан. Энэ төсөвлөсөн саналаас бол энэ ямар төсөв хасагдсан гэхээр Улс төрийн намын хуулийг хэрэгжүүлэх бүтцийн нэгжийн төсөв тэр чигээрээ хасагдсан байгаа юм. Тэгээд тийм, тэгэхээр тэр үүнийг хянаснаас хойш Улсын Их Хурлын тогтоол гарч, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоосон. Тэгэхдээ бид нар тэр дээд хязгаарт шууд тулгаж хийхгүй гэж байгаа. Тэгээд бид нар 24 онд нэг 40 орчим орон тоотой байхаар төлөвлөсөн. Тэгээд энэний Улс төрийн намын хуулийг хэрэгжүүлэх бүтцийн нэгжийн орон тоо болон төсөв нь хасагдаад нэг 2,1 тэрбум төгрөг хасагдчихаад байгаа юм.

Бид ирэх жил бүр ядахдаа 2,1 байдаггүй юм аа гэхэд бид нар энэ задаргаагаар нь хэлэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын 1 тэрбум 88 сая төгрөг. Энэнээс ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 136 сая, ингээд нийтдээ нэг тэрбум 225 сая төгрөг бол бүр зайлиггүй хэрэгтэй байгаад байгаа юм. Улс төрийн намын хуулийн хэрэгжилтийг хангах бүтцийн нэгжүүдээ бий болгоод, хүний нөөцөө

бүрдүүлээд, ажлаа жигдлээд явахад ийм юм зайлиггүй хэрэгтэй байгаад байгаа гэдгийг л хэлэх байна. Баярлалаа.

Н.Энхболд: Ганболд гишүүн тодруулах уу?

Г.Ганболд: Жавхлан сайд намайг нэм гэсэн гэж л байна лээ л дээ. Би хэлсэн үгээ санаж байна. Би бол бүгдийг нь адилхан зарчмаар л нэм гэж хэлсэн юм. Энэ үнийн зөрөөг. Магадлангаар орно гээд зарим нь ингээд түрүүлээд магадланд оруулчихсан, зарим нь төсөвт өртгөө ингээд саяын багийн төвийн жишээгээр ярихад 4 дахин нэмүүлж байна шүү дээ. Ийм магадлан гэж бол хаана ч байхгүй ээ. Одоо ингээд магадлангаар ороод энэ чинь Төсвийн хуулиараа бол би худалдан авахын хуулиар хэрэв үнийн зөрөө нэмэгдсэн бол 15 хувь дээр нь л тэр компани дээр нэмэлт гэрээ хийх ёстой. Илүү тавигдсан бүх мөнгөн дээр тендер зарлах ёстой. Энэ дээр Үндэсний аудитын газар энэ дээр сайн ажиллах ёстой юм байгаа юм шүү. Энэ магадлан хийлгээд зарим нь энэ төсөвт өртгөө 2, 3 дахин даблдаж энэ төсөв дээр дарамт учруулж байгаа юм зөндөө байгаа шүү. Ноднин өчнөөн 100 тэрбум төгрөг орсон, энэ жил бас орсон. Одоо энэ бол цаашдаа ингээд үргэлжлээд байх юм бол энэ чинь өөрөө энэ төсөв дээр асар том дарамт ирнэ шүү дээ. Тэгээд үүнийг зайлиггүй ер нь нэг тийш нь гаргаж ... /минут дуусав/

Н.Энхболд: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Ганболд гишүүний асуултад нэмэлт зүгээр, мэдээлэл өгье. Ер нь энэ үнийн өсөлттэй асуудал ер нь их зовлонтой юм байна. Энэ ковидтой холбоотой сүүлийн 2, 3 жилийн энэ үйл явдалтай холбоотой ер нь маш их ийм үнийн өсөлттэй асуудал гарч ирж байгаа. Үүнийг ер нь яг энэ цаг хугацаанд нэг тийш нь дуусгаж авах нь их чухал. Тэгэхгүй бол энэ хойшоогоо төслүүд нь ч дуусахгүй, удах тусмаа улам эрсдэлд орно, улам л үнэтэй болно. Ингээд нэг зөв

механизмаар нь үүнийг ямар ч байсан төслүүдээ осолдохгүй нэг дуусгаад авах нь их чухал байгаа юм. Ингээд ноднин, уржнан бол гишүүд энэ төсөвт өртгийг нэмж аль гэж их шаардаж байсан.

Харин саяын таны хэлдэг шиг зүгээр хэн нэг хүний үзэмжээр 20 хувь, 30 хувь бүгдийг нь нэмнэ, тийм хууль байхгүй шүү. Та өөрөө төсвийн эрхлэн захирагч байсан, Засаг дарга байсан хүн. Маши сайн ойлгож байгаа хүмүүсийн нэг нь. Төсвийг хэзээ ч нэг үзэмжээр тэгж жигд нэмдэг тийм юм байхгүй. Төсөл бүр дээр заавал мэргэжлийн үнэлгээний байгууллагаар экспертиз оруулаад тэгээд шаардлагатай бол аудитор оруулаад ингээд явдаг. Нэгэнт ингээд хавтгайрч байгаа учраас үүнийг бүгдийг нь экспертиз оруулсны дараа заавал аудитаар ядаж оруулъя гэдэг бид нар ийм шалгуур тавьж байгаа. Харин одоо Их Хурал дээрээс үүнийг дахиж магадлах шаардлагатай бол үүнийг ер нь нэг магадлах нь дээр шүү, магадлах ёстой шүү гэдгийг харин бид нар удаа дараа хэлээд байгаа юм. Удаа дараа хэлж байгаа юм. Ёстой энэнээс дээш хөх тэнгэр бол байхгүй болчихоод байгаа юм, бид нарт. Үүнийг оруулахаас өөр арга байхгүй, дуусгахаас өөр арга байхгүй. Харин энэ дээр эргэж Улсын Их Хурал дээрээс хяналт тавих түр хороо ч хамаагүй байгуулаад ингээд явчихвал сайн л байна. Тийм, тэгж л хэлэх байна даа. Тэрнээс биш үзэмжээр тэгж тэдэн хувь, хэдэн хувь, хавтгайд нь бүгдэд нь жигд эд нар гэж ерөөсөө огт болохгүй.

Н.Энхболд: Ойлголоо. Адьясүрэн гишүүн асууя. Картаа хийгээгүй юм биш байна лээ шүү. Наадах чинь аппарат нь ажиллахгүй байгаа юм болов уу. Солихоос өөр аргагүй. Энэ чинь одоо бараг худалч хүнд 20-оод жил болж байгаа тоног төхөөрөмж шүү дээ, тийм. Адьясүрэн гишүүний микрофоныг өгье.

А.Адьяасүрэн: Товчхон 2 асуулт асууя. Энэ 2024 онд Тогтворжуулалтын

санд 513,7 тэрбум төгрөг, Ирээдүй өв санд 1,4 их наяд төгрөг тус тус хуримтлуулахаар энэ төсвийн төсөл дээр тусгасан байна. Эдгээр сангийн үлдэгдэл яг одоогийн байдлаар ямар хэмжээтэй байгаа вэ? Мөн энэ сангуудын үлдэгдлийн тодорхой хэсгүүдийг санхүүгийн зах зээл дээр байршуулах, арвижуулах зэрэг ямар арга хэмжээ авч байгаа вэ? Энэ талаар бас тодорхой мэдээллийг авмаар байна.

Мөн 2 дугаарт нь, түрүүн Үндэсний аудитын газрын тайланд 2024 оны төсвийн төсөл өнгөрсөн хавар баталсан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байгаа талаар дурдсан. Энэ талаар бас тодорхой мэдээллийг авмаар байна.

Н.Энхболд: Жавхлан сайд Тогтворжуулах сангийн одоогийн байдал, арвижуулах ямар арга хэмжээ авч байна вэ, авч болох вэ?

Б.Жавхлан: Адьясүрэн гишүүний асуултад хариулъя. Тэр арвижуулах гэдгээс эхлээд хариулъя. Бид нар энэ дээр маш хатуу зарчимтай байх ёстой. Арвижуулах гэж байна гэж давхиж байгаад л баахан алдчихсан байдаг юм. Одоо тэр Нийгмийн даатгалын сан баахан банкнууд дээр тавьж алдсан чинь ерөөсөө л тийм байгаа. Эхлээд найдвартай эсэхийг нь харалгүйгээр, өндөр хүү амласан руу нь аваачиж хийгээд, тэр чинь аль болох өндөр л амлах тусмаа цаана нь том эрсдэл дагуулж байдаг. Цаашидаа бид нар ингэж явж болохгүй ээ. Тийм учраас хамгийн найдвартай газраа эхлээд хадгалагдах ёстой. Найдвартай байж чадвал цаашидаа өгөөж хайж болох юм гэдэг ийм зарчмаар явна гэсэн үг. Тийм учраас энэ Төрийн сан дээр бүрэн бүтэн хадгалагдаж байгаа. Ирээдүй өв сангийн одоогийн үлдэгдэл 2,7 их наяд байгаа. Ирэх жил ингээд дор хаяж 3,4 их наядас дээшээ болоод явна.

Тогтворжуулалтын сан бол Адьясүрэн гишүүн ээ, жил болгон энэ

нольлодог сан шүү. Жилийн эцсээр нь нольлож гардаг сан. Өөрөөр хэлбэл манайх уул уурхайгаас тогтворжуулсан үнээс үнэ нь даваад, илүү орлого олсон бол тэрийгээ шууд тухайн жилийнхээ төсвийн алдагдал руугаа шууд хаагаад нь үлдэгдэлтэй гардаг. Жил болгон нь үлдэгдэлтэй гардаг ийм сан гэсэн үг. Тийм.

Н.Энхболд: Болсон уу, Адьаа гишүүн ээ. Баярлалаа.

Занданишатар дарга.

Г.Занданишатар: Гишүүд, ажлын хэсэгт өдрийн мэндчилгээ дэвшүүлье. Ер нь энэ тоног төхөөрөмж байна шүү дээ. Гацаж байгаа нь бол Сангийн яаманд өгч байгаа анхааруулга гэж бодож байна. Энэ яагаад гэхээр бараг 20 жилийн өмнө ашиглалтад ороод Солонгосын буцалтгүй тусламжаар одоо энэ үйлдвэрлэгдэхээ больчихсон, хэрэглээнээс хасагдчихсан юм байгаа юм. Тэгээд үүнийг шинэчлэх төсөвт суусан байсныг Сангийн яам бахархалтайгаар Улсын Их Хурал гишүүдийн тоогоо нэмсэн учраас сандал, ширээ авах гэж байна гэж зарлаж, нэг бөөн шуугиан л болсон л доо. Хүүхдийн төсөв хасаад ингэчихлээ, юу ч гэх нь ээ. Тэр нь яах вэ, гол нь биш. Энэ чинь тэгсэн чинь энэ төрийн Төсвийн хэмнэлтийн тухай хуулиар хориглочихсон конторын барилгуудыг өөр нэр өгөөд энэ 24 оны төсөвт өртөг 68 тэрбум төгрөг, анхны өртөг 38 тэрбум төгрөг байсан чинь дотор 1 дүгээрт, Төрийн хэмнэлтийн хуультайгаа нийцэж байгаа юм уу.

2 дугаарт, энэ магадлалаар ороод ингээд төсөвт өртөг нэмэгддэг. Энэ асуудлууд ер нь юу болж байгаа юм? Яагаад гэхээр энэ ард түмэн ерөөсөө энэ төсвийн хөрөнгө оруулалт, тендер чинь энэ автобус шуухнаас авхуулаад ерөөсөө бүх шатанд ард түмний дургүйг хөдөлгөж байна. Энэ тендерийн хөрөнгө оруулалтын чинь үр ашиг хаана байгаа юм? Энэ магадлал энэ тэрийн цаана чинь

авлига, хээл хахууль нуугдаж байдаг юм уу, юу болж байгаа юм, энэ ерөөсөө. Анх тендерт орохдоо тэгвэл түүгээрээ тохирч орчхоод, яагаад ингээд төсөвт өртөг хэд дахин нэмэгдүүлээд байдаг юм. Тендерийнхээ өртгөөр л хийх ёстой шүү дээ. Зөвхөн нэг жишээ, сая гаргаж ирэхэд чинь энэ багийн төвийн хэдэн тэрбум төгрөгийн дотор энэ 66 тэрбум төгрөг ингээж явж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 3.1-д зааснаар төрийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Энэхүү эрхээ өөрсдөө төрийн эрхэд шууд оролцож болон төлөөлөгчдийн байгууллагаар дамжуулж эдэлнэ ээ гэж заасан. Татвар, төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын үндсийг Улсын Их Хурал тогтооно гэж заасан. Хөгжлийн бодлого тогтвортой байна гэж заасан. Гэтэл одоо болохоор ингээж Монгол Улсын Үндсэн хууль олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмын дагуу Монгол Улс бүрэн эрхийнхээ хүрээнд улсын гадаад дотоод бодлого, тэр дундаа татвар, төсөв, эдийн засгийн бодлогыг тодорхойлох бүрэн эрхтэй байдаг бөгөөд энэхүү эрхийг бол төрийн эрх дээд байгууллага Улсын Их Хурал хэрэгжүүлдэг байхаар Үндсэн хуульд тусгасан. Төрийн эдийн засгийн санхүү төсвийн бодлогоо тодорхойлоход ОУБ бусад улс орнууд хөндлөнгөөс нөлөөлөх нь улсын дотоод хэрэгт үл оролцох зарчмыг зөрчихөөр байна.

Татвар бий болгох, түүнийг хөнгөлөх, чөлөөлөх асуудал нь улсын бүрэн эрхэд хамаарах Улсын Их Хурлын эрх хэмжээний асуудал. Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг Засгийн газар Улсын Их Хурлын өмнө хариуцах үүрэгтэй бөгөөд НӨАТ-ын хууль тогтоомж буцаан олголттой холбоотой асуудлаар Засгийн газраас Улсын Их Хуралд шаардлагатай мэдээллийг хүргүүлж, зөвлөн туслах чиг үүрэгтэй болохоос Сангийн яамнаас тусгай зөвшөөрлийг нь олгодог эрх олгосон харьяа төрийн бус байгууллага, олон

улсын байгууллагуудыг өдөөн турхирах замаар төрийн бодлогод нөлөөлөх оролдлого хийж байгаа нь зохисгүй үйлдэл гэж үзэж байна.

Дэлхийн бусад улс орнуудын хувьд НӨАТ нь ялгамжтай хувь хэмжээгээр ногддог бөгөөд бууруулсан хувь, супер редюст, редюст гээд 2003 оны Европын тайлан дээр ч гэсэн ийм стандарт үйлчилж байна. Зарчмын хувьд өргөн хэрэглээний бараа зэрэг зайлшгүй хэрэгцээ болон хүүхдийн хувцас, ном гэх мэт бараа бүтээгдэхүүнд улс орнууд 5-6 орчим хувийн НӨАТ, бусад хураамж 20 орчим хувийн 21 дунджаар, 21 хувийн НӨАТ болон худалдааны татвар оногдуулж байна. Энэ агуулгаар 5 хувийн буцаалт гэдгийг татварын урамишуулал гэхээс илүү татварын хөнгөлөлт, буцаан олголт гэдэг агуулгаас ч тайлбарлаж болно.

Гэтэл төсвийн хөрөнгө оруулалт дотор 2024 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9,1 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 3,2 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй, 1049 арга хэмжээ туссан байгаа. Үүнээс 5,1 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,6 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй, ишлжих 552 төсөл, арга хэмжээ, 4 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 1,6 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй, 497 төсөл хөтөлбөр байна.

Шинээр хийгдэх төсөл, хөтөлбөрөөс улсын хэмжээнд хийгдэх 245 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 төсөл, арга хэмжээг хэрхэн хуваарилах талаар тодорхой мэдээлэл ирүүлээгүй. Гишүүдэд мэдээлэл ирүүлэхгүй байгаагаас өмнөх Байнгын хороодод үл ойлголцол гарсан байна.

Энэ 2024 оны төсвийн төсөлд шинээр тусгагдсан хөрөнгө оруулалтын нийт 1,6 их наяд төгрөгийн 245 тэрбум төгрөг нь улсын хэмжээнд зарцуулах төсөл, хөтөлбөрүүд байна.

Мөн 2024 оны төсөвт хэрэгжих, хэрэгжиж дуусах боломжгүй төсөл, арга хэмжээ байгааг анхаарах шаардлагатай байна.

Үндэсний аудитын газраас гаргасан тайланд тусгасан зөрчил арилгуулах тухай 2 албан шаардлагын хэрэгжилт энэ жилийн төсөв батлахаас өмнө арилсан уу? Үндэсний аудитын газраас гаргасан 2 албан шаардлага бол 24 оны төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан, төсөвгүй болон нэг маягийн зураг төсөвтэй, холболтын зураг төсөлгүй, зөрчилтэй, хуулийн шаардлага хангахгүй, эдийн засгийн үр ашиг нийгмийн ач холбогдолтой эсэх нь тодорхойгүй 215 төсөл, арга хэмжээ ишиг хуулийн шаардлага хангаж байгаа эсэх нь тодорхойгүй арга хэмжээг дахин дахин оруулж ирж байгаа гээд анхаарах шаардлагатай.

Энэ мэтчилэн төсвийн 1, 1 зүйлийг харвал энэ Гочоогийн Ганболд гишүүний ярьж байгаа зөв шүү дээ. Яагаад гэвэл ард түмэн энэ төсвийн хөрөнгө оруулалт, тендер, энэ үр ашгийн чинь асуудлыг бүгдээрээ ярьж байна. Ийм учраас энэ асуудал хөндөгдөж байгаа юм.

Нийтийн санхүү бол хөгжлөөс 15-20 жилээр хоцорчхоод байна. Public finance улсын санхүү дээр зарлага, төсвийн зарлага, төсвийн орлого уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийн маань далд эдийн засаг ямар болж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний НӨАТ-ыг 2009 онд чөлөөлсөн. Энэнээс орлого алдаж байгаа юм уу, үгүй юм уу. Яагаад нэмүү өртөг шингээгээд гаргаад байгаа тэр уурхайнууд жишээ нь жишээлбэл нэмүү өртөг төлж болохгүй байгаа юм гэх мэтчилэн маш олон асуудлыг хөндөж энэ асуудлуудад ард иргэдэд саналаа илрүүлж байна.

Ийм учраас энэ зохион байгуулалттай энэ хууль хэлэлцэх явцад зарчмын хүрээнд энэ дэгийн тухай хуулийн дагуу бол мэтгэлцээн зохион байгуулах, энэ дэлхийн Өргөдөл гомдлын тухай хуулиуд и-битийшний бүх хуулиудаар энэ ном журмаараа ингээд санал ирлээ. Энэ бүх судалгаа хийгдсэн олон улсуудын. Энэ өргөдөл, гомдлыг хэлэлцүүлдэг тусгай процедур журамтай. Тэгэхээр энэ асуудлуудыг хүндэтгэлтэй хандахыг би бас албан ёсоор хэлмээр байна. Бүх баримт, материалуудаар нотлогдож байна, энэ асуудлууд.

Төсвийн үр ашгийг бид сайжруулах шаардлагатай. Ард түмний татвар төлөгчдийн мөнгийг ямар хэлбэртэй үрэн таран хийж байгааг саяын бүх сенсац харуулж байна шүү дээ. Ард түмний и-баримтын олголт байсан бол энэ олон хүлгэй, зэлгий хүртэл ард түмний энэ 3,5 сая иргэдийн хяналтад оруулъя гэдгийг яагаад эсэргүүцээд байгаа юм. Ийм учраас энэ төсвийн үр ашгийг нэг бүрчлэн энэ хөрөнгө оруулалтуудын үр ашиг, нийгэм, эдийн засгийн ач холбоодыг тэр Аудитын газрын дүгнэлттэй нийцүүлж хянах хэрэгтэй. Тийм учраас Аудитын газар татварын хэрэгжилттэй холбоотой хийсэн тайлан дээр автомашин болон татвар авахгүй байгаа, НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой мэдээллийг Улсын аудитын ерөнхий газар, тэр автомашины татварууд төлөгдөхгүй байгаа, тэр татварын хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаа асуудлаар тайлбар хариулт өгнө үү.

Тэгээд энэ 245 төсөл, арга хэмжээний талаар тайлбар өгнө үү? Аудитын газрын дарга Занданбатаас асууж байна.

Д.Тогтохсүрэн: Их Хурлын дарга санал ярьсан. Тэгээд 1 асуулт асуусан. Аудитын ерөнхий газрын дарга Занданбат дарга байна уу, байхгүй бол

Наранчимэг хариулах уу. Эхлээд Наранчимэг хариулна. Дараа нь Жавхлан сайд хариулна. Наранчимэг 240 объект тус бүрийн үнэлгээтэй холбоотой асуудлыг ярьж байна шүү дээ.

Ц.Наранчимэг: Улсын Их Хурлын даргын асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллагаас Улсын Их Хурлын гарсан 72 дугаар тогтоолын дагуу магадлал хийлгэчихсэн төсөл, арга хэмжээн дээр аудитын байгууллага баталгаажуулж, дүгнэлт гаргаж байгаа. Магадлал хийлгээгүй бол дүгнэлт гаргахгүй байгаа. Нийтдээ бид 211 дээр 73,8 тэрбум төгрөгийн төсөвт өртгийг магадлалаар бууруулж баталгаажуулсан байгаа. Энэ дээр бид энэ жилийн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтдээ хойшид барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийлгэх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах гэрээ байгуулах, захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, улсын комисс барилга байгууламжийг хүлээж авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулж, субъектив гаднын нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой цогц ийм зохицуулалт хийх шаардлага байна гэдгийг төрийн аудитын байгууллагаас дүгнэлтдээ оруулаад Засгийн газарт энэ чиглэлээр бас зөвлөмжийг хүргүүлсэн байгаа.

Ер нь бол магадлал хийлгэж байгаа зураг төсөл маань энэ нэмэгдэж байгаа төсөвт өртөг маань юунаас болж байна вэ гэхээр нэг маягийн зураг төсөлтэй төсөл, арга хэмжээг холболт хийгдэх ч юм уу байршлыг нь солих, маш олон шалтгаанаас болж энэ төсөвт өртөг нэмэгдэж, хугацаандаа энэ төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх ийм шалтгаан нөхцөл бий болж байгааг аудитын тайланд бид бас тодорхой асуудлуудыг дурдаж гаргаж өгсөн байгаа.

Худалдан авах ажиллагааг эхэлж зохион байгуулчхаад, тендерт шалгарсан компани нь дахиад ажил нэмэгдсэнээс болж энэ төсөвт ирдэг, нэмэгдэх бас шалтгаан болж байгаа. Энэ дээр 2 албан шаардлагыг бас Засгийн газарт энэ тайлангаар албан шаардлага хүргүүлсэн байгаа.

Татварын хуулийн шинэчлэлээр бид нийцлийн аудитыг хийж, тайланг Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Энэ тайлан дээр бид татварын асуудлаар сөрөг болон эерэг нөлөөллүүдийг бас энэ тайланд бол тодорхой дурдаж өгсөн байгаа, дүгнэлтүүдээ өгсөн байгаа. Энэ тайланг 2 албан шаардлагыг бид хугацаа болоогүй. Энэ 2 албан шаардлага нь бол энэ дараагийн 11 сард төсвийн төслийн тооцооллыг хийхдээ батлагдахаас өмнө Улсын Их Хуралд өргөн барихдаа саяын энэ магадлалтай холбоотой, зураг төсөлтэй холбоотой төсөл арга хэмжээн дээр гараад байгаа энэ асуудлуудыг дахин давтан гаргахгүй байх талаар 2 албан шаардлагыг хүргүүлсэн байгаа, Засгийн газарт хүргүүлсэн.

Д.Тогтохсүрэн: Занданшатар дарга тодруулга 1 минут. Занданшатар даргын микрофон.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын төсөв 12 тэрбумаар сандал, ширээ хөрөнгө оруулалтын төсөв гэж мэдэгдсэн. Энэ сандал, ширээнээс энэ тоног төхөөрөмжийн зардал гэж энэ чинь бичээстэй байхад яагаад тийм мэдэгдэл хийсэн юм бэ?

Хүүхэд хамгааллын төсөвтэй харьцуулж Их Хурлын төсөв асар их нэмэгдлээ гэж яриад байдаг. Тэгтэл энэ бүх төсөв чинь, төсөвт өртгүүд чинь бүх энэ төсвийн энд байгаа ерөнхийлөн захирагч чинь тэрнээс илүү их нэмэгдсэн байна шүү дээ. Тэр талаар биш яагаад зөвхөн түүнийг онцолж та яриад байгаа юм?

Д.Тогтохсүрэн: Жавхлан сайд хариулт. Сангийн сайд Жавхлан сайдын микрофоныг.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын даргын асуултад хариулъя. Энэ жил Улсын Их Хурлын Тамгын газраас 2 ч удаа албан бичгээр, нийтдээ 22 тэрбум төгрөгийн барилга, засвар, тоног төхөөрөмж шинээр худалдаж авах ийм хөрөнгийн зардал, урсгал зардал биш, дахиж онцолж хэлье. Хөрөнгийн зардлын ийм санал ирүүлсэн. Үүнийг Сангийн яам хянаж үзээд 1 төгрөг ч хасаагүй, яг ирүүлсэн саналаараа бүтнээрээ суусан байгаа. Суусан байгаа. 2 төрлийн хөрөнгийн зардал гэсэн үг. Барилга байгууламж, засвар, тоног төхөөрөмж. Тоног төхөөрөмж дотор барилга засвар хийгдсэнтэй холбогдоод тавилга юмнууд ч байгаа. Мөн энэ яг ордон доторх бүтэн энэ цахим төхөөрөмжүүдийн, системээр нь энэ олон жил болсон 10 хэдэн жил болсон, 10 хэдэн жил болсон гэлээ бүтнээр нь солих ийм төсөвтэй ийм хүсэлт ирсэн. Тэр чигээрээ суусан байгаа гэсэн үг.

Д.Тогтохсүрэн: Жавхлан сайдын минутыг сунгая.

Б.Жавхлан: Үүнийг онцолж хэлсэн зүйл юу байх вэ дээ. Төсөв өргөн баригдсаны дараа бид Засгийн газар дээрээс хэвлэлийн хурал хийж байхдаа асуулт байсан. Би тэр 12 тэрбум төгрөгийн тэр тоног төхөөрөмж түүнийг нь би хэлсэн байгаа. Тэрнээс биш хүүхэд хамгааллын асуудалтай бол ерөөсөө огт холбоо бид нар тийм ямар нэгэн мэдэгдэл хийгээгүй ээ гэдгийг хариуцлагатай хэлж байна.

Ганболд гишүүний хэлж байгаатай бол бид нар 100 хувь нийлж байгаа. Энэ үнэхээр энэ хүний өсөлтийн юм бол энэ ковидыг дайраад, дэлхий даяар л бид нар ийм үнийн юунд нэрвэгдэж байна. Тэгээд Улсын Их Хурлын харьяа байгууллага Төрийн аудитын газартаа л бид эцэст нь итгээж

эднийх аудит хийгээд эцсийн байдлаар гаргаж өгөөч ээ гээд ингээд явуулсан байгаа. Үүнийг л нэг эргэж харах нь зүйтэй болов уу л гэж би ингэж хэлсэн юм.

Д.Тогтохсүрэн: Занданишатар дарга дахиад тодруулга 1 минут. 2 удаа бол асууна, 7 минутыг би мэдэхгүй байна.

Г.Занданишатар: Улсын Их Хурлын төсвийг ингээд задлаад сайхан ярь, хэлэлцье, хасчих шаардлагатай бол. Би тэр 12 тэрбум төгрөгийн асуудал бас 22 тэрбумыг нь хас хас. Хэрвээ шаардлагагүй ээ гэж үзэж байгаа бол. Сангийн яамны зардлаар тэр бүх зардлыг хас. Ийм л юм яриад байгаа улсууд байгаа юм.

Д.Тогтохсүрэн: Дарга сая үг хэллээ. Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Би Занданишатар даргын хэлж байгаа, санал гаргаж байгаа, дэвшүүлж байгаа асуудлыг бүгдийг нь дэмжиж байгаа. Санал нэг байгаа.

2 дугаарт, хүнсний аюулгүй байдал, лабораторийн шинэчлэл, хүн амын хүнсний аюулгүй байдлын асуудал нэн хурцаар тавигдаж байгаа. Хавдар, өвчлөл, үхэл залуужиж байгаа, нэмэгдэж байгаа. Харамсалтай нь энэ дээр огт анхаарал хандуулахгүй байгаа. Би Сангийн яаманд энэ хүнсний аюулгүй байдал, хүн амын хүнсний хэрэглээ, тэр дундаа одоо нян бактери, хими, цацрагийн шинжилгээ хийдэг энэ сүүлийн 10 гаруй жил хамгийн сүүлд БНХАУ-ын буцалтгүй тусламжаар шинэчлэгдсэн энэ лабораторийг бүрэн шинэчилж чаддаггүй юмаа гэхэд нэг 10 тэрбум төгрөгийн төсөв тавиад өгөөч ээ гээд 2 жил дараалан ярьж байгаа. 1 ч төгрөгийн төсөв тавигдаагүй. Тэгээд ийм байхад бид нар 27 их наядын төсөв баталж байж энэ стандартын лабораторийн хүнсний аюулгүй байдлын

асуудал хангах энэ байгууллагаа гаргууд нь хаячихсан. Тэгээд өнөөдөр бид нар энэ идэж байгаа хүнснийхээ пестицидийг ч шинжилж чадахгүй байгаа шүү дээ. Пестицидийг. Та бүхэн тэгээд бодоод үзээрэй. Бүхэл бүтэн улс, тусгаар тогтносон улс. Тэгээд яах вэ, хөрөнгөтэй, мөнгөтэй, албан тушаалтай зарим хүмүүс нь өвдөж цангах, өлсөх юм бол үнэтэйг нь, хамгийн чанартайг нь аваад идчихдэг байх. Гэтэл цаана нь байгаа энэ 3 сая гаруй хүн амыг бодож байгаа зүйл ерөөсөө огт байхгүй байна. Эсвэл энэ хүнсний аюулгүй байдлыг хангая гэж ярьж байгаа, асуудал дэвшүүлж байгаа хүнийх нь хувь хүн нь таалагдахгүй байгаа юм уу? Нэг бол Үндсэн хуулиар эрүүл аюулгүй амьдрах орчинд энэ эрхээ эдлэх, иргэдийн эрх ашиг таалагдахгүй байгаа юм уу? Нэг бол энэ хүн амыг бүр аажмаар бодлогоор устгах ийм далд бодлого явж байгаа юм уу? Би бол сүүлдээ учрыг нь олохоо байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр хөрөнгө оруулалт хийх тийм боломж байна уу, байхгүй юу?

Монгол Улсын хэмжээнд өнөөдөр хүнсний аюулгүй байдлын лаборатори нийт тоног төхөөрөмжийн 80 гаруй хувь нь хуучирсан, хийх ёстой шинжилгээгээ хорьхон хувийг нь хийж чадаж байгаа гэдгийг та бүхэн бүх шатдаа нэг санаад авчхаарай. Тэгээд ийм байхад бид нар эрүүл амьдрал, аюулгүй амьдрал гээд өчнөөн эд хөрөнгө, зам барилга гэж тавиад нэмэр байна уу, үгүй юү? Би Сангийн яаманд бүх саналаа хүргүүлсэн. Засгийн газар дээр ч ярьсан. Өнөөдөр үүнийг ярихаас өөр аргагүй ийм байдалд орж байна, 1 дүгээрт.

2 дугаарт, энэ онцгой байдлын албан хаагчдын хувцас, хэрэглэл, тоног төхөөрөмж гээд гал, ус, ковид, гамшиг, тахал гээд л бүх юманд явдаг энэ хүмүүсийн нэг хувцас хэрэглэлийг шинэчлээд өгчихье. 30 тэрбум төгрөг тавиад өгөөч гэсэн одоо гараа татаж, татаж нэг есхөн тэрбум төгрөг тавьсан. Үүгээр бүхэл бүтэн хэдэн

мянган албан хаагчдын өнөөдөр гал дунд нүцгэн явж байгаа хүмүүс шүү, энэ хүмүүс. Тэгээд гал, ус, аюул тохиолдохоор бид нар хамгийн түрүүн эмнэлэг, цагдаа, онцгойг дууддаг. Тэгээд хамгийн сүүлд төсөв тавигддаг, ийм байдалтай явж байгаа юм. Энэ хөрөнгө оруулалтыг шийдэх боломж байна уу, үгүй юү, 2 дугаарт үүнийг асууя. Өнөөдөр 4 алба хаагч тутмын 1 нь хувцастай яваа, 3 нь хувцасгүй явж байгаа гэж. Тэгээд одоо ой хээрийн түймэр, объектын гал түймэр, халдварт өвчин, тахал гэхээр бүгдийг нь түлхээд явуулдаг. Сандал ширээ авах болохоороо бүгд хамгийн сүүлийн үеийн компьютероос нь ... /минут дуусав/

Д.Тогтохсүрэн: Жавхлан сайд хариулт өгнө. Засгийн газар дээрээ ярьчихгүй яасан юм бэ дээ, наад асуудлаа.

Б.Жавхлан: Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Амарсайханы асуултад хариулъя. Одоо бид нар хуульд өгсөн, хуулиар өгсөн үүргийнхээ дагуу Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын төсвийг төсөвлөөд, төлөвлөөд хэдүүлээ хамтдаа хэлэлцээд 09 сарын 29-нд хугацаандаа Улсын Их Хуралд өргөн бариад өнөөдөр Улсын Их Хурал үүргийнхээ дагуу хэлэлцэж байгаа шүү. Та ингээж попрох, өөрийгөө бодох байсан юм бол Засгийн газар дээр ярихгүй яасан юм? Одоо битгий ингээж битгий ингээж хийрх, тойргийнхоо асуудлыг Монгол Улсын Засгийн газрын хийж байгаа ажилтай холбож битгий ингээж яриарай. Би бүр хэлээд өгье. Та ер нь өөрийнхөө төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд ажлаа мэддэггүй юм байна. Таны ирүүлсэн санал дотор чинь сая байгаль, тэр юутай хүнстэй холбоотой лабораториудын санал энэ жил ирээгүй шүү. Ирээгүй шүү, хоёулаа түүнийг чинь тэгвэл энд гаргаад тавьчихъя. Юу юу ирсэн юм гээд. Харин өөрийнх чинь тойрог дээрээ санал ирсэн юман дотор чинь болохгүй, зураггүй,

төсөв дийлэхгүй юмнууд зөндөө байгаа. Тэрнийхээ уурыг энд гаргаад хэрэггүй шүү.

Одоо төсөв өөрчлөх боломж байна уу гэж хэнээс асууж байгаа юм, мэдэхгүй. Улсын Их Хурал дээр энэ асуудал эцэслэж шийдэгдэнэ. Засгийн газар дээр бүх боломжоороо бид нар үүнийг шийдээд оруулсан байгаа. Хэрвээ тоо ярих гэж байгаа бол энэ жил төсвийн ерөнхийлөн захирагч нараас нийлээд энэ чинь 12 их наядын төсөвт өртөг бүхий санал ирсэн шүү, шинээр 12 их наядын. Үүнийх чинь 300 тэрбум төгрөг л орж байгаа, санхүүжүүлэх дүн нь. Энд яаж багтааж, яаж явж энэ ингээж төсөвт багтаж орж байгааг өөрөө зовлонг нь мэдэж байгаа шүү дээ. Ганц нэг аймаг руу нь цуг явсан, харж байгаа байх, мэдэж байгаа байх. Энд орж попроод хэрэггүй шүү.

Д.Тогтохсүрэн: Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Би 1 л зүйл тодруулъя.

1900 уучлаарай, 2015 онд батлагдсан Монгол хэлний тухай хуулиараа Монгол Улсын төрийн албан байгууллагууд бүгдээрээ Монгол бичиг буюу давхар бичигтэн болно. Яг энэ дээр бид нар бэлтгэл хэр хангаж байгаа вэ гэдэг зүйлийг бид нар бас ярилцаж Монгол хэлнийхээ үгсийн санг арвин байлгах, зөв хэлтэй Монгол иргэнээ бий болгох төлөвшүүлэх тал дээр бас нэг ажлын хэсэг гараад ажиллаж байгаа юм. Энэ ажлын хэсэг дээр юу яригдсан бэ гэвэл Ерөнхийлөгчийн дэргэд байдаг Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын алба гэж алба. Энэ ажлын алба 4 алба хаагчидтай, 4 орон тоотой ажилладаг. Цалингаас өөр ямар ч төсөвгүй. Монгол хэлээ, Монгол бичгээ төрийн бичиг болгох тэр бэлтгэл хангах, судалгаа шинжилгээний ажил хийх ямар ч төсөв байдаггүй юм байна. Яг өнөөдөр орж ирж байгаа төсөв дээр хэлний

бодлогын үндэсний зөвлөлийн ажлын алба нийтдээ 439,4 сая төгрөг гэдэг нэг ийм тоотой орж ирж байгаа юм байна. Зүгээр Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын гүйцэтгэх үүрэг дээр болохоор судалгаа шинжилгээ хийх, бэлтгэл хангуулах гээд олон чиг үүрэг байдаг болов чиг түүнийгээ хэрэгжүүлэх тэр боломж нь төсөвтэй байдаггүй учраас гэдэг ийм зүйлийг ярьж байна. Энэ дээр бид нар нэгэнт 2025 оноос хэрэгжүүлж эхлэх Монгол хэлний тухай хууль, төрийн албаны бичгээ Монгол бичгээр эрхлэх гэж байгаа энэ ажлын бэлтгэлийг хангах үүднээс тодорхой хэмжээний төсөв нэмж өгч болох уу?

Ер нь Ерөнхийлөгчийн Тамгын газраас энэ тал дээрээ санал оруулсан юм болов уу. Төсөв дээр ямар нэгэн өөрчлөлт оруулах тэр боломж байна уу гэдэг зүйлийг тодруулах гэсэн юм. Баярлалаа.

Д.Тогтохсүрэн: Сангийн сайд Жавхлан. Зарлагын дарга чинь оруулах ярих юм уу, хэн хариулт өгөх юм. Сангийн яамны зарлагын хэлтэс, газрын дарга байгаа юм уу. Энэ зарлага асуугаад байна шүү дээ. Төсвийн зарлагатай. Ерөнхийлөгчийн Тамгын газраас хүн байна уу. Төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүүгийн хүмүүс нь. Ерөнхийлөгчийн Тамгын газрын хүмүүсээ дуудаарай, бас асуугаад байна.

Жаргалмаа гишүүн тодруулъя гэсэн тийм ээ, Жаргалмаа гишүүн тодруулга.

Б.Жаргалмаа: Даяаришиж байгаа нийгэмд бид нар Монголоо авч үлдэхийн тулд энэ Монгол хэлний тухай хууль ч гэсэн батлагдаж, төрийн үндэсний бодлогын зөвлөлтэй болж, Үндэсний хөтөлбөр батлагдаж бас тодорхой хэмжээний Загийн газар 2020 оны 11 дүгээр сард ч гэсэн дэмжиж ажиллах ийм шийдвэрүүд гаргасан. Тогтоолууд гаргасан болов чиг энэ ажил маань ийнхүү бодит болох боломжгүй байгаа

энэ нөхцөлд Сангийн яам энэ дээр бас анхаарч ажиллаасай. Яагаад Ерөнхийлөгчийн Тамгын газар энэ асуудлыг ийнхүү зүгээр л нэг 4 хүнийг орон тоог цалин өгөх гэж байлгаж байгаа юм бол доо. Хэрвээ хэлний бодлогын зөвлөлийг үнэхээр ажиллуулах гэж байгаа бол ажиллах тэр боломжийг нь нээж өгөөч ээ гэдэг хүсэлтийг Байнгын хорооны хурал дээрээ тавьж байна.

Д.Тогтохсүрэн: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2023 оны төсөв 371 сая төгрөгөөр батлагдаад, ирэх жил 69,3 тэрбум төгрөгөөр нэмэгдээд 440 сая төгрөг болсон байгаа юм байна шүү.

Манай Шадар сайд энэ ОБЕГ-ынхаа, жишээ нь төсвүүдийг өөрөө ер нь орж ирснийг нь харсан юм уу, үгүй юм уу. 70,3 тэрбум төгрөгөөр ОБЕГ-ын төсөв нэмэгдсэн байна шүү, 70,3 тэрбум төгрөгөөр. ОБЕГ, батлан хамгаалах, цагдаа гэх мэт төрийн цэргийн байгууллагуудын хувцас, хоол, шатахуун, засвар гэх мэт нормативт зардлуудыг 24 оны төсөв дээр анхаарч, 68 тэрбум төгрөгөөр нийтэд нь нэмсэн байгаа. Ийм өөрчлөлтүүд нэмэгдсэн байгаа.

Таны хэлснээр 30 тэрбум, 30-тай байна гээд бүгдийг нь нэмээд байх юм бол төсөв хүрэхгүй ээ.

Н.Энхболд: Тодруулах юм байхгүй юу тийм ээ. Нэрээ өгсөн гишүүд асууж дууслаа. Асуулт дууслаа.

Одоо төсөл. Гишүүд асуулт тавьж, хариултаа авлаа. Одоо санал гаргаж явна. Тэгэхдээ дэг сануулчихъя. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.8-д нам, эвслийн бүлэг, гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал гаргасан бол бусад төсөл, хөтөлбөр, арга

хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах саналыг хамтад нь гаргаж, 1 санал болгон санал хураалт явуулна. Саналуудыг багцлан хурааж болно. Санал явуулахын өмнө тухайн саналтай холбогдуулан Засгийн газрын тайлбарыг сонсож болно гэсэн дэгийн заалттай.

Саналтай гишүүн байвал нэрээ өгье. Хэн бэ? Амарсайхан сайдаар тасаллаа. Амарсайхан сайдын микрофоныг өгөөрэй.

Нэг 2, 3 санал байна. 3.2-ын. 3.1 дээр 24-25 онд Стандарт хэмжил зүйн газрын лабораторийн тоног төхөөрөмж зардалд 10 тэрбум төгрөг. Хасагдах зардал нь 16.1.24 дээр Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн 11 тэрбум төгрөгөөс 2 тэрбумыг нь хасах саналтай байна гэж. Үгүй ээ, үгүй энэ тойрог би ерөөсөө огт яриагүй шүү. Би харж байгаад энэ нүдэнд харагдсан тоон дээр л.

Н.Энхболд: Та бичээд өгчих. Тэр цаас өгөөдөх. Зарчмын зөрөөтэй.

С.Амарсайхан: 24 онд санхүүжих энэ соёлын салбарын тоног төхөөрөмж 10 тэрбум төгрөг гэснээс 2 тэрбум төгрөгийг хасах гээд би саналаа энэ томьёолоод биччихсэн байж байгаа.

Н.Энхболд: Наашаа өгчих.

С.Амарсайхан: 3 дугаарт нь энэ шинэ нисэх Зуунмодыг холбох 110квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын 110 3510-ын дэд станц энэ 24 онд санхүүжих дүнгээс 10 тэрбумаас 1 тэрбум төгрөг хасъя гээд. Ингээд ийм 3, 4 юунуудаас төсвөөс нэгтгээд энэ 10 тэрбумын саналыг гаргаж байгаа юм.

Энэ Стандарт хэмжил зүйн газрын хүнсний лабораторийн тоног төхөөрөмж. Одоо бид нар энэ хүнснийхээ доторх хорыг хэмжиж

чадахаа болчихоод байгаа байхгүй юу. Тийм, үгүй ээ ирэлгүй яадаг юм бэ, наадах чинь та нар чинь. Би зүгээр бүгдийг нь маш тодорхой бичиж өгсөн шүү дээ. Энэ чинь ямар хүнсэнд, ямар жимс ногоо идэж байгаагаа мэдэхгүй хэмжээ улсын хэмжээнд байгаа гээд л тэрийгээ л бодчих гээд байгаа шүү дээ. Тэрнээс би гэртээ лаборатори тавья, миний тойрогт зам тавиад өг гэж үүнийг яриагүй. Шаардлагатай бол миний тойрогт байгаа тэр тавина гээд тэр 3 тэрбум төгрөгийн манай тойргийн тэр мөнгийг хасаад тавьчих аа л гэж байгаа. Манай тойргийн иргэд энэ нийт иргэдийн асуудлаас нэг их тийм одоо гомдоод элдэв янзын асуудал үүсгээд байхгүй байх. Улсын хүн амын эрүүл мэндтэй холбоотой асуудал дээр.

2 дахь саналаа хэлье, дарга. Энэ онцгой байдлын газрын алба хаагчдын хувцас, хэрэглэл, тоног төхөөрөмжид манайх саналаа хүргүүлсэн юм. Тэгээд энэнээс 9 тэрбум төгрөг тавигдсан байгаа юм. Тэгээд яах вэ, энэ 24 онд санхүүжих дүнг нь 9 тэрбум гээд, нийт санхүүжих дүнг нь 40 тэрбум гэж тавья гэдэг ийм 2 дахь санал гаргаж байгаа юм. Санхүүжих дүнг нь төсөвт өртгийг нь нэмэгдүүлэх. Биччихсэн энэ саналаа ингээд өгчихье.

Үгүй ээ, одоо тэгээд хөндөхөөс өөр аргагүй асуудал байна шүү дээ, Тоогий дарга аа, энд, тийм.

Н.Энхболд: 1 дүгээрт, би бас саяыг юу яаж байсан юм, бодсон юм. Засгийн газар кабинетаараа хэлэлцээд оруулаад ирсэн төслөө гишүүн сайд нь ингээд өөрчлөөд санал гаргаад байх нь зарчмын хувьд нийцэж байна уу, үгүй юү гэдэг асуудал байна. Яах вэ, хураая гэвэл тэгээд хураая. Энэ нь болох уу, үгүй юү гэдэг дээр нь эхлээд би санал хураачихъя гэж бодож байна. Тийм зарчимтай л ажиллаж байгаа шүү дээ, бид нар бүгдээрээ. Тийм ээ. Тэгээд хураая гэвэл саяын томьёолсон саналуудаар санал хураана.

Саналтай холбогдуулаад Засгийн газрын тайлбарыг сонсож болно гэж би сая дэг дээр уншсан. Энэ Жавхлан сайд саяын саналтай холбогдуулаад тайлбар хэлбэл сонсьё, Байнгын хороо.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга асуусан учраас би байр сууриа илэрхийлье. Монгол Улсын Засгийн газар төсвийг төлөвлөх үүрэгтэй. Төлөвлөөд бид нар цаг хугацааны 9 сарын 29-нд цаглаврынхаа дагуу 9 сардаа багтаад Засгийн газар дээр хэлэлцээд, эцэслээд ингээд өргөн барьсан байгаа. Одоо бол ингээд Улсын Их Хурал маань төсөв батлах гээд эрх нь бол энэ институцтэй байдаг. Ингээд тэрнийхээ хүрээнд хэлэлцээд явж байгаа. Гишүүнийхээ хувиар ямар ч санал гаргаж болох байх. Зүгээр яах вэ, би кабинетын гишүүний хувьд Монгол Улсынхаа Шадар сайдад хандаж хэлэхэд хэдүүлээ ярилцаад Засгийн газар нэгдсэн саналаараа өргөөд барьсан энэ төсвөө энэ ямар нэг салбарын төсөв биш, энэ тойргийн төсөв биш. Энэ Монгол Улсын төсөв. Монгол Улсын төсөв чинь өөрөө хязгаартай, хязгаартай боломжтой. Би дахиад хэлье. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын ирсэн санал 12 их наяд төгрөг шүү. Хөрөнгийн зардал нь. Бид нарын багтааж чаддаг боломж нь 300 тэрбум л юм байгаа юм. Хэрвээ энийгээ мэдэхгүй, хэрвээ энэ ингээж өөр өөрсдийн салбарын амбицаа барьж ингээж ярих юм бол бүх сайд нар ярина. Чухалгүй салбар гэж байхгүй, чухалгүй хөтөлбөр гэж байхгүй, энд. Зүгээр ингээж ярьж байгаа нь харамсалтай, миний хувьд. Нэгэнт Байнгын хорооны дарга асуусан учраас хариулахаас өөр аргагүй. Тийм учраас Засгийн газрын гишүүд өргөн барьсан төсвөө үлгэр жишээ энэ Улсын Их Хурал, гишүүд олон нийтийн өмнө ингээд хамгаалаад гарах нь зөв болов уу гэж би зарчмын санал хэлж байна. Тийм.

Н.Энхболд: Би сая бас дэгтэй холбогдуулаад хэлсэн. Тэгээд оруулж ирж байгаа энэ ялангуяа гишүүн нь

хамаа алга. Засгийн газрын сайд нар ийм санал гаргаад түүнийг нь Байнгын хороо хураах нь зөв үү, үгүй юү гэдэг дээр эргэлзээд байна. Тийм учраас Байнгын хороодынхоо саналыг сонсоно. Санал хураая.

Сайд нараас Засгийн газраас оруулж ирсэн төсвийн төслөөс зөрсөн зарчмын зөрөөтэй саналаар санал хураая гэдэг томъёоллоор сонсодохъё. Санал хураалт. Байнгын хорооны гишүүд санал өгнө. Хураах уу, үгүй юу гэдэг. Эндээс ажиглагдана даа. Тэгээд та дараа нь байр сууриа илэрхийлнэ биз, Шадар сайд аа.

Ийм байдалтай байна. 12 гишүүнээс 2 нь дэмжсэн байна. Бусад нь бол үгүй гэсэн байна. Санал хураагаад ч ер нь явахгүй шинжтэй л байна. Яах вэ. Дэмжээд хураая гэсэн шүү дээ, би. Яг тийм утгаар л асууж, тийм утгаар санал хураалт явуулсан юм.

Юу яая. Ер нь ийм боломж бий. Төсвийн ажлын хэсэг дээр Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг байгаа. Ахлагч нь Тогтохсүрэн гишүүн ажиллаж байгаа. Төсвийн байнгын хороо дээр орж энэ асуудлаа дахиж ярьж болно.

Ганболд гишүүн нэг хэлчих, тийм. Амараа сайд аа, түр. Амараа сайд. Ганболд гишүүний микрофоныг өгчих.

Г.Ганболд: Тойргийн саналаас гарахыг нь шууд бичгээр гаргаад л өгчихвөл тэр чинь асуудалгүй шүү дээ. Лаборатори яриад байх юм. Энэ мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгахад би бол асар их эсэргүүцэж байсан шүү дээ. Тэрний нөгөө өмнө байгаа лаборатори хаана байгаа юм. Аймгууд дээр мэргэжлийн хяналтын барилга гээд шинэ барилга лабораторитой нь барьчихсан. Түүнийг Стандартчилал хэмжил зүйн төв рүү шилжүүлж өг гэж би танаас зөндөө гуйсан шүү дээ. Тэр аймагт байгаа шинэ

барилгуудаа лабораторитой нь улсын бүртгэл энэ тэрд алдчихаад та хөөцөлдөхгүй яваад байна шүү дээ. Тэд нарыгаа ав л даа, би хэлээд байгаа шүү дээ. Стандарт хэмжил зүйн газарт тэр лабораторид байна тэр барилгуудаа шилжүүлээд өгөөч ээ, хөөцөлдөөд өгөөч ээ, засаг дээрээ яриагч ээ, энэ Төрийн өмчийн хороо дээр яриад түүнийг аваач ээ гээд би тань руу зөндөө хэлээд байгаа шүү дээ. Ерөөсөө хөөцөлдөхгүй. Тэгээд тэрэнд нь шал өөр байгууллага очоод тэр лабораторидоо шинэ барилгад нь ороод суучихсан. Үгүй ээ, наадхыгаа эхлээд хөөцөлдмөөр байна шүү дээ. Засаг дээр. Тэгэхгүй бол энэ чинь ингээд бөөн сүүлд нь ингээд өөр газарт алдчихаад, ямар ч лаборатори хэрэггүй байгууллагууд оруулчихаад, бүхэл бүтэн цоо шинэ лаборатори барилгуудаа ингээд өөр байгууллагад ашиглуулчихаад энэ Стандартчилал хэмжил зүйн төв үүнийг хөөцөлдөх хэрэгтэй байна шүү дээ.

Н.Энхболд: Бололцоо бол Төсвийн байнгын хороо дээр байна, ажлын хэсэг дээр саналаа бас тийш нь өгч болно.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Байнгын хороо хийж дууслаа. Төсвийн байнгын хороонд санал, дүгнэлтээ явуулах ёстой. Тогтохсүрэн дарга аа, манай Байнгын хороо Төсвийн байнгын хороонд давхар хийдэг хүн нь та юм байна. Та Төсвийн байнгын хороон дээр дүнгээ Байнгын хорооны санал, дүгнэлт танилцуулчихаарай.

2 дахь хэлэлцүүлэг хэлэлцээж дууслаа.

17.03 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд, “Тогтоолын

хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Байнгын ажлын хэсгийн нэр хаана байна. Ажлын хэсэг хэвээрээ байгаа.

Нөгөө ном дээр чинь байгаа, гишүүн ээ. Дагалдах хуулиуд, төсвийн номын ард бүх хуулиуд байж байгаа, тийм.

Хуулийн төслүүдтэй холбогдуулаад асуух гишүүд нэрээ өгье. Би дараа нь асууна, бас нэг асуулт байна. Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Одоо би жишээ нь Төрийн албаны зөвлөлөөс асуух уу, Сангийн яамнаас асуух уу. Төрийн албаны хууль.

Төрийн албаны хууль дээр энэ аймгийн төвийн сумд ажилласан 1 жилийг 1,3 жилээр, сумд ажилласныг сум, тосгонд ажилласныг 1 жилийг 1 жил 6 сараар дүйцүүлэх ийм санал орж ирсэн. Ажилласан жилтэй холбоотой. Тэгэхээр яах вэ, энэ яах вэ. Нөгөө төвлөрлийг сааруулах бодлогынхоо хүрээнд ингээд байж байгаа зүйл. Тэгээд энэ шатлан дэвших тогтолцооныхоо нөхцөлд энэ зарчим хэрэглэгдэх ёстой гэж бодоод байгаа байхгүй юу. Тэгээд тийм зүйл бол 1 дүгээрт бол энэ ерөөсөө огт харагдахгүй байгаа юм.

Аймгийн төвийн сумд гэдэг чинь аймгийн төв дээр байгаа бүх хүн энд хамрагдах нь ээ 1,3 жил болох нь ээ л гэж ойлголоо шүү дээ.

2 дугаар асуудал. Энэ нягтлан бодогч нарыг албан тушаалын ангилал, зэрэглэлийг тухайн салбарт ажиллаж байгаатайгаа яг адилхан тооцчихож байгаа юм. Тэгээд яах вэ, нягтлан бодогч нар жаахан хохироод байгаа юм харагдаж байгаа юм. ТҮ-гийнх гээд нөгөө ТҮ-дээ ороод ингээд доошоо яваад байгаа юм харагдана. Гэхдээ үүнийг заавал

ингээд нэг оруулж ирээд энэ нэг хуулийн нэг бүтцийг эвдсэн, албан тушаалын нэрээр нь хуульчилчихсан юм харагдаад байгаа юм. Ерөөсөө Төрийн албаны хуульд албан тушаалын нэрээр хуульчилчихсан юм байхгүй шүү дээ. Тийм. Тэгээд тэр тэртээ тэргүй ТЗ-ийн 6-гийн алба албан хаагч бол зургаагаараа, наймынх бол наймаараа, арвынх бол арваараа л явах ёстой байхгүй юу. Тэгэхээр яах вэ, Төрийн албаны зөвлөл ч юм уу нэг журам гаргаад үүнийг заавал яахгүй, хуульд оруулахгүй явчхаж болдоггүй юм байх даа. Заавал хуульд чинь нэг нягтлан гэдэг ганцхан албан тушаал бий болох гээд байна шүү дээ. Хуульд. Нөгөө хуулийн бүтцийг эвдээд байгаа юм харагдаад байгаа юм. Тэгээд үүнийг заавал хуульчлах шаардлага байгаа юм уу гэж би асууж байгаа юм.

3 дахь асуудал нь, нөгөө юутай холбоотой асуудал байгаа юм. Нэг Засгийн газрын тогтоолтой холбоотой, тогтоол дээр асууна, тийм ээ. Нөгөө бүтцийн тогтоол дээр газрын агентлагийг дээш нь татаад Ерөнхий сайдын агентлаг болж байгаа. Бодвол Засгийн газар нэлээн сайн ярилцсан л байх л даа. Одоо чинь ний нуугүй ярихад бүрэн эрхийн хугацаа зургаахан сар байна шүү дээ. Энэ төсөв чинь 6 сар хэрэгжинэ шүү дээ. Бүрэн эрхийн хугацаа. Тэгээд 6 сарын хугацаанд ингээд бүтцийг оролдоод байх шаардлага ер нь байгаа юм уу, бодвол их л хэрэгтэй л болчихоод байгаа байх даа, энэ гэсэн ийм нэг 3 зүйлийг тодруулъя. Баярлалаа.

Н.Энхболд: Би ер нь яг адилхан асуулт асуух гэж байсан юм. Хуультай холбоотой тэр нөгөө нягтлан бодогчийг заавал нэрээр нь ингэж тусгаж, Төрийн албаны хууль дотор онцгойлж оруулах хэрэг байна уу. Бусад зүйлээр бусад актуудаар зохицуулж болох уу гэж Хэрэг эрхлэхийнхэнтэй ярьсан. Их Хурлын Тамгын газартай ярьсан. Ингэж оруулахгүйгээр зохицуулах боломж байгаа. Засгийн газар өөрөө шийдээд явах боломж бий гэж хариулсан байгаа

шүү. Тийм учраас үүнийг дүгнэлтдээ оруулах хэрэгтэй гэж бодож байна. Тэгээд Жавхлан сайд хариулъя. Хэн хаана байна, Баасандорж байна уу. Дууд. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тогтохсүрэн даргын асуултад хариулъя. Яах вэ, би бол зовлонгоо л ярих юм шүү. Ямар зовлон байгаа юм, тэгээд үүнийг яаж шийдэх гэж оролдож байгаа юм, ямар үр дүн гарах вэ гээд. Одоо манай сумд төрийн сангийн нягтлан солигдлоо гэхэд ажлаа өгөөд явлаа гэхэд оронд нь тавих шаардлага хангасан хүн олдохоо байчхаад байгаа юм. Үгүй ээ, яг нягтлан мэргэжилтэй тэгээд Төрийн сан дотроо нягтлангийн чиглэлээр ажиллаж байсан тийм хүнийг л тавихаас өөр аргагүй болчихоод. Тэгээд ноднин, уржнан бол нэлээд хэдэн сум дээр ийм асуудлууд гараад баларсан. Тэгээд цалингаас болоод буцаж орж ирэхгүй, тэгээд шинээр хүмүүс тэнд шаардлагыг нь хангаж орж ирж чадахгүй гээд. Тийм учраас ядаж төрийн сандаа биш юм бай гэхэд сумынхаа захиргаан дээр нягтлангийн чиглэлээр ажиллаж байгаад, тэгээд тийшээ шилжих боломжийг нь л нээж өгөх гээд байгаа юм. Ийм л боломж байгаа юм. Ийм л юм хараад байгаа юм зүгээр. Үүнийг хуульд зохицуулалт хийхгүйгээр хэрвээ дагасан журмуудаараа хэрвээ болдог гэвэл сайн л байна. Тэгвэл маш сайн л байна.

Н.Энхболд: Санжаадорж дарга энэ дээр нэг тайлбар хийчих үү? Би бас болно гэж үзэж байх шиг байна. 1 номерын микрофон өгчихдөө.

Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Эхний заалт нь 1 жилийг 1 жил 3 сараар, хэрвээ аймгийн төвөөс бусад сумд байх юм бол 1 жилийг 6 сараар тооцох гэж асуудал бол зөвхөн карьерын систем дээр бол бид нар оруулж ирсэн. Энэ өөрөө хөндөж байгаа заалт нь болохоор 23.2 дээр гэхээж

байгаа юм. Тэгэхлээр шатлан дээр дэвших асуудал дээр. Тэгэхээр шатлан дэвших асуудал бол зөвхөн ТЗ дээр байгаа төрийн захиргаан дээр. ТҮ дээр энэ бол шатлан дэвших дээр тооцохгүй. Бусад одоо юу гэдэг юм тэтгэвэрт гарахад болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн хугацаа энэ тэр дээр бол нөлөөлөхгүй. Зөвхөн шатлан дэвших дээр гэдэг дээр агуулгаар орж ирсэн байгаа. Энэ дээр болно гэж орж ирчхээд тэгээд нарийвчилсан зохицуулалтыг нь бол Засгийн газраас батлахаар холбогдох зохицуулалтыг оруулахаар ажлын хэсэг дээр ярьж байгаа ийм асуудал байгаа.

Нягтлангийн асуудал ингэсэн. Ер нь бол Төрийн албаны тухай хууль дээр тусгайлан яг мэргэжлийг оруулсан заалт одоогоор 1 заалт бол байгаад байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр нөгөө ID-ийн инженерүүдийг нэг оруулаад ирчихсэн асуудал байгаа. Тэгээд ажлын хэсэг дээр бид хэд үүнийг бас ярьж байгаа. Тэгээд Засгийн газар бол нөгөө цалин тогтоох асуудал дээр яг цалингийн шатлалыг ялгаа байхгүй, эрүүл мэндийнхийг эрүүл мэндийнх, боловсролыг боловсрол гээд тусад нь тогтоож байгаа. Тэр дундаа оруулаад тогтоох боломж бол хэрвээ байна аа гэж үзэх юм бол дагах тогтоол дээрээ бас эрхээ авах асуудал. Хэрвээ хуулиар авахгүй бол тогтоолоор эрхээ авъя аа гэдэг зүйлийг бол бас ярьж байгаа. Ажлын хэсэг дээр.

Н.Энхболд: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Баярлалаа, Энхболд дарга аа. Би зүгээр нэмэлт тодруулга хийх гэсэн юм. Өчигдөр Ёс зүйн байнгын хороон дээр 1 асуулт гарсан юм. Тэгээд түүн дээр би нэг нэлээн ойлгомжтой тайлбар хэлсэн. Гэтэл түүнийг өнөөдөр тасалж, гуйвуулаад тэгээд аль болох л энэ төсвийг л муухай харагдуулах гэж л зорилготой хийдэг юм уу, яадаг юм тэр зарим нэг телевизүүд ийм буруу мэдээлэл өгчихсөн байна лээ. Тэр нь юу вэ гэхээр манай энэ төрийн албатай л холбоотой юм. Төрийн алба дотроо төрийн

тусгайгийнхан ТТ-ийнхэн маань алслагдсан аймаг, сумдад ажиллахдаа 5 жил тутам буюу 60 сар ажиллаад 1 удаа 30 сар хүртэлх тэнцэх хэмжээний цалингийн урамшуулал нэмэгдэл авдаг юм авдаг. Энд ямар ч өөрчлөлт байхгүй, цаашаагаа ингэдгээрээ явдгаараа явна. Би юу гэж нэмж оруулсан бэ гэхээр төрийн тусгай мөртөө эндээс хоцорчихсон 1 л алба байгаа юм. Тэр нь гаалийнхан байдаг юм. Гаалийнхан төрийн тусгай мөртөө энэ нэмэгдлийг авдаггүй.

Харин энэ удаа ямар өөрчлөлтүүд орж ирж байгаа ... /минут дуусав/

Н.Энхболд: Микрофон нэмээд өгчихье.

Б.Жавхлан: Орж байгаа л гэсэн үг л дээ. Одоо юу орж ирж байгаа вэ гэхээр Төрийн албаны тухай хуулиар ТЗ-нүүд 5 жил тутам 6 сарынхыг бүгдээрээ авдаг болж орж ирж байгаа. Гэтэл энд ерөөсөө гаалийнхан ерөөсөө ТТ мөртөө ТТ-ээсээ бүр ингээд огт тас ноль. ТЗ-ийнхэн бас ингээд өөрчлөгдөж байхад, авдаг болж байхад бас ингээд хоцроод үлдчихэж байгаа юм. Тийм учраас бусад параллель ТТ-үүдийнхээ 30 сар дээр бас арай хүрэхгүй шүү дээ, яг. Тэгээд ТТ-ийнхэн арай илүү авдаг тэр зарчмаараа нэг 12 гээд дундажлаад л орж ирж байгаа юм. Гэтэл тэр авч байгаа 30-ийг 12 болгож буулгах гэж байна гэж тэгж худлаа гуйвуулж, аваачиж тайлбарлаад одоо тэгээд ТТ-ийнхнийгээ аваачиж сандаргаад. Тэгвэл их сайн байна. Тэгвэл 30 болгоод өгөөч. Манай Пүрэвдорж гишүүн бол гаальчин байсан, мэргэжлийн мундаг гаальчин хүн. Үүнийг санал оруулаад 30 болгочихдог их сайн байна. Тэгээд ийм санал оруулж ирсэн шүү. Тэгэхээр одоо байгаа ТТ-үүдийн 30 сар хэвээрээ, хоцорсон гаалийг энд нэмж оруулж байгаа санал байгаа юм. Миний санал. Түүнийг дэмжиж өгөөрэй л гэсэн юм.

Н.Энхболд: Энэ манай Байнгын хороо дээр яригдахгүй л дээ. Тийм. Баатарзориг дарга нэг тайлбар хэлчихье. 2 номерын микрофон дээр очоорой. Нягтлан бодогчдоо, Баатарзориг дарга аа. Төрийн албаны зөвлөлийн дарга Баатарзориг нягтлан бодогчтой холбоотой зэрэглэл, ангиллын асуудал дээр асуултад хариулъя.

Тоогий дарга хурал битгий үймүүлээд байгаарай.

Б.Баатарзориг: Байнгын хуралдааны өмнө хэлэлцэх асуудал дээр бэлтгэл ажлын шугамаар бас Сангийн яамныхантай 57 дугаар зүйлийн Төрийн албаны хуулийн 57.18 дахь хэсэг дээр өөрчлөлт оруулахаар оруулж ирсэн санал байгаа. Яг томъёоллоороо бол төсвийн байгууллагын нягтлан бодогчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг тухайн салбарын төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэлтэй адил байхаар тогтоож болно гэдэг ийм заалт оруулахаар санал оруулж ирсэн. Нягтлан бодогч нарын ажлын байр олон сул байгаа. Нөхөлт байхгүй байгааг ойлгож байгаа. Гэхдээ салбар салбараар нь яг албан тушаалаар нь ингэж хуульчлаад салгаж авах нь буруу жишиг гээд. Тэгээд Сангийн яамныхантай бас зөвлөлдсөн. Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол дээр өөрчлөлт оруулах маягаар энэ асуудлыг тогтоолын түвшиндээ шийдээд явах боломжтой. Тэрнээс биш нягтлангуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх, сул орон тоог хангалтыг сайжруулахтай холбоотой зарчимтай бол нэг байгаа. Үүнийг зарчмыг хэрэгжүүлэхэд заавал хууль дээр ингэж оруулахаас журам дүрмээр зохицуулах боломжтой гэдэг дээр Сангийн яамныхан, холбогдох ажлын хэсгийнхэнтэй тогтчихоод байгаа юм. Үүнийг илэрхийлье.

Бусад одоо ер нь Төсвийн тухай хуулиар төрийн албан хаагчдад 2 гол реформын чиглэлтэй зөв ажлын эхлэл тавигдаж байгаа. 1 дүгээрт нь, цалин

хөлсний нэмэгдэл үе шаттайгаар үргэлжилж байна.

2 дугаарт нь, орон сууцын хангалтуудыг сайжруулах чиглэлийн ажлын эхлэлүүд үргэлжилж байгаа. Товч танилцуулахад ийм байна. Баярлалаа.

Н.Энхболд: Тогтохсүрэн гишүүн бид 2-ын асуулт давхацсан учраас би асуухаа болилоо.

Хуулийн төслийг заалт бүрээр нь хэлэлцэж явна.

1 дүгээр заалттай холбогдолтой тэр тайлбарыг хүлээж авч болмоор юм байна лээ. Энэ дээр яах вэ, би чуулган дээр хэлж байсан л даа. Нэгэнт ийм зарчим оруулж байгаа бол шууд тооцно гээд оруулчихвал яасан юм бэ гээд. Тэгэхээр бас тайлбарууд хэлж байна лээ. Энэ ажлын үр дүнтэй холбож үзэж байж зүгээр л оноор нь л бодоод л нэмээд байдаг ийм бол бас зохисгүй ээ. Үйл ажиллагааны үр дүнтэй нь холбож үзэж байгаад тэгээд тухай тухайн газраа шийдээд явах нь зүйтэй тийм, тийм гарц гаргахын тулд тооцож болно гэж оруулсан гэж тайлбар хэлсэн. Түүнийг нь бас би бол хувьдаа хүлээж авах нь зүйтэй гэж бодсон юм.

1 дүгээр заалтын 57.18-ын хувьд бол яах вэ, одоо санал хураагаад үзье. Дэмжигдээд явбал шаардлагатай гэвэл ажлын хэсэг дээр дахиад нэг ярина биз. Дэмжигдэхгүй хасагдана гэвэл саяын Баатарзориг даргын хэлснээр Засгийн газрын шугамаар энэ асуудлаа өөрөө шийдэж болно гэдэг тайлбарын дагуу шийдээд явах нь зүйтэй. Ер нь зүгээр ингээд хууль болгон дээр хуулиуд дээр нэг албан тушаалаар юм уу, эс үгүй бол нэг мэргэжлээр ингээд заагаад байх нь өөрөө жоохон зохисгүй л дээ. Тэр хуулийнхаа үндсэн концепт юмыг алдагдуулаад байдаг юмтай юм байгаа юм.

Ингээд зүйл зүйлээр нь санал хураалт. Хаана байна 23 гэж. Одоо

ингээд л зүйл зүйлээр нь явна шүү дээ. 3 зүйлтэй. 3 зүйлтэй хууль байгаа.

Дөнгөж сая тайлбар хэллээ, нөгөө тооцож болно гээд. Түүнийг дараа нь журмаар нарийвчилж зохицуулаад, ажлын үр дүнтэй нь холбоод, тухай тухай үед нь шийдээд явах. Тийм, тийм. Үгүй ээ, одоо ингээд харин зүйл зүйлээр нь ярихаар тэгээд ярина шүү дээ. 1 дүгээр зүйл гээд. Тэгэхээр үгүй үгүй, би зүгээр тайлбар л хэлсэн. Одоо ингээд эхнээсээ явна. 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйл гээд явна.

Ингээд хуулиараа зүйл зүйлээр санал хураана. Гишүүд анхааралтай хандаарай.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: 23.9 дээр Улаанбаатар хотоос тухайн орон нутагт иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэж, төрийн захиргааны албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан иргэнийг энэ хуулийн 23.2-т заасан томилогдох хугацааг аймгийн төвийн сумд 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сараар, аймгийн төвөөс бусад сум, тосгонд ажилласан жил ажилласан хугацааг 1 жил 6 сараар ажилласандаа тус тус дүйцүүлэн тооцож болно гэж. Тэгээд энэ ингээд Улаанбаатар хотоос Ховдын Дуут сумд очоод ажиллалаа гэхэд яг нэг захиргааны албан тушаал дээр очих нь л дээ. Тэгэнгүүт тэр нь тэнд ажиллаж байгаа 1 хүн нь болохоор жилээрээ л ажиллаад байдаг. Нөгөө хүн нь тэгсэн чинь Улаанбаатар хотоос нэг шилжиж ирсэн болчихоод 1 жил 6 сараар тооцуулаад ажиллаад байдаг тийм одоо. Тэгэнгүүт нөгөө тэр төрийн албан хаагч нь юу гэх юм. Тийм. Тэгвэл Улаанбаатар хот руу шилжиж нэг 2 сар ажиллахаад буцаж ирээд шилжиж ирээд тэгээд дахиад л 1 жил 6 сараар тооцуулах нь

байна шүү дээ. Үгүй ээ, тэнд нэг хотоос ирсэн хүн аягүй бол ажилдаа гологдоод тэнд очиж байгаа юм. Дуут руу очихгүй шүү дээ. Тэгээд энд очингуут нь нэг яг хажуу талтай зэрэгцээд адилхан ажил гүйцэтгэдэг. Тэгэнгүүт нь нэг нь 1 жил 6 сараар бодогдоод байдаг, нөгөөдөх нь яг адилхан ажил хийчхээд 1 жилээр бодогдуулаад байдаг. Наадах чинь нөгөө нэг тэнд байгаа ажилтан албан хаагчдын юмыг бас тодорхой хэмжээгээр шийдэхгүй бол наадах чинь аймаар ялгавартай зүйлийг хэлж байна шүү дээ. Тэгээд би бол ингэж хэлэх юм байна. Нөгөө тэр Дуутын нөгөө нэг хажууд нь ажиллаж байгаа хүн гомдоно шүү дээ. Бас. Пүрэвдорж гишүүн ээ энэ нөхөр ирээд надтай яг адилхан ажил хийж байна. Тэгсэн мөртөө 1 жил 6 сараар бодуулаад байдаг. Би 1 жилээр. Тэгэнгүүт нь би юу гэх вэ гэхээр, үгүй ээ чи хот руу яваад шилжчихээд нэг 2 сар ажиллахаад буцаад ажиллачихгүй юу даа л гэж хэлэх гэж байна. Ийм л юм хийх нь байна шүү дээ.

Н.Энхболд: Санал сонслоо, ойлгосон, ойлгосон. Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр энэ ийм юм шүү дээ, Пүрэвдорж гишүүн ээ. Энэ нөгөө хөдөлмөрийн хөлс тооцохтой холбоотой ч юм уу, ажилласан жил тооцохтой холбоотой ч юм уу, нийгмийн даатгалын нөгөө тэтгэвэрт гарахтай холбоотой ажилласан тооцохтой холбоотой асуудал огт биш. Энэ зөвхөн албан тушаалын шатлан дэвших тогтолцоотой холбоотой асуудал. Миний асуугаад байдаг нь энэ. Өөрөөр хэлбэл нөгөө карьерын зарчмаар явж байгаа ТЗ-ийн жинхэнэ албан хаагчдын хувьд л 23, 24 дүгээр заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал байгаа юм. 1 дэх нь тэгж ойлгоно.

Зүгээр яах вэ, 2 дахь нь бол үүнийг Пүрэвдорж гишүүн тодорхой санал байвал хэлнэ биз. Би зүгээр, миний бодол энэ Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ирж хөдөлгөөн хийлгэсэн

гэдгийг бүртгэл хийлгэсэн гэдгийг бол бараг хасчихмаар юм даа. Ер нь зүгээр сумд ажиллаж байгаа тохиолдолд 1 жилийг 1,3-аар, аймгийн төв дээр шаардлага байна уу үгүй юү? Үүнийг нэг ажлын хэсэг дээр яриад л ингээд цэгцэлчихмээр юм. Үгүй ээ, энэ тэгээд нөгөө нугалаа үүснэ шүү дээ. Аягүй хэцүү, тийм.

Н.Энхболд: Засгийн газраас л уг нь энэ дээр ямар бодлого барьж, ийм заалт оруулж байгаа юм гэдгээ хариулсан нь зөв байх даа. Баасандорж 3 номер.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Баасандорж Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дэх заалт буюу энэ 23.9-ийг ярьж байна. Та бас Пүрэвдорж гишүүн ээ, 23.9, 23.10 тайлбар гээд байгаа. 23.10 дээр бол энэ хуулийн 44.1-д заасны дагуу буюу өөрөөр хэлбэл 44.1 бол шилжүүлэн ажиллуулах гэдэг зохицуулалт байгаа Төрийн албаны хуулийн. Шилжүүлсэн ажилласан тохиолдолд энэ бол хамаарахгүй ээ. Энэ заалтыг яагаад Засгийн газраас оруулж байна гэхээр Хот, хөдөөгийн сэргэлтийн үндэсний хороо ажиллаж байгаа. Энэ үндэсний хорооны гол зорилго нь хотоос хөдөө рүү гэдэг зарчмыг барьж байгаа. Өнөөдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 1,6 сая бараг 1,7 сая иргэн ажиллаж байна. Оршин сууж байна. Суманд сүүлийн жилүүдэд суманд, аймагт ялангуяа алслагдсан бүс, таны тойрог, Ховд аймаг, Ховд аймгийн харьяа сумдад төрийн албан хаагчийн хүний нөөц бол маш багасаж байгаа. Тэгэхээр бид нар энэ төвлөрлийг сааруулах ажлын хүрээнд энэ хэрвээ хотод ажиллаж байгаа хүн сумд очиж ажиллаад, энэ аймагт очиж ажиллах юм бол энэ ажилласан жилийг нь ийм байдлаар тогтооно гэдэг зорилготойгоор үүнийг хийж байгаа. Гэхдээ шилжүүлэн ажиллах бол энд хамаарахгүй. 44.1.

Н.Энхболд: Би энэ энэ хууль дотор барьсан байж байгаа 23.2 гэдэг заалтыг хуульд өөрөөр заагаагүй бол доор дурдсан төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан иргэнийг томилно. Тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 12-оос доошгүй жил ажилласан байна. Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх гээд ингээд ийм болзлууд байж байгаа юм. Тэгэхээр энэ бол шилжүүлэхдээ л чи хөдөө 3 жил ажилласан байна, тийм ээ. Тийм учраас чиний энэ хугацааг нь жосоохон богинохон богиносгоно гэсэн үг шүү дээ. Богиносгож өгнө гэсэн үг шүү дээ, тийм.

Асуулт, санал сонслоо.

Гишүүд ээ, анхааралтай байгаарай. Одоо би 1 дүгээр зүйлээр санал хураалгах гэж байна. 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 57.18 төсвийн байгууллагын нягтлан бодогчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг тухайн салбарын төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлтэй адил байхаар тогтоож болно гэдгийг нь хасъя гэсэн санал хураах гэж байна. Хасвал түрүүн ярьсны дагуу Засгийн газрын журам тогтоолоор шийдээд явах боломжтой. Санал хураалт.

Энэ бүртгэлд орсон гишүүд байхгүй байна даа. Хэвээрээ үлдлээ шүү.

1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Хэлэлцэж дууслаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Байхгүй байна.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт, нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Баярлалаа.

Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ярина.

Хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Санал хураалт явуулъя, гишүүд ээ, анхааралтай хандаарай.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу. Байхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай, асуулттай гишүүн байна уу. Алга байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Энэ хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё.

“Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Дэгийн тухай хуулийн 94.1-д Монгол Улсын Их Хурал энэ хуулийн 9 дүгээр бүлэгт зааснаас бусад асуудлаар тогтоол гаргах бол хэлэлцэх эсэх, анхны болон эцсийн хэлэлцүүлгийн үе шаттайгаар хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд энэ хуульд заасан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх журмыг баримтална гэсний дагуу хэлэлцэнэ.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төсөл дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Жаргалмаа гишүүн уншъя, шинэ гишүүнээрээ уншуулчихъя.

17.31 цаг

Дараагийн асуудалд оръё.

Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргын тухай асуудал хэлэлцэнэ.

Их Хурлын тухай хуулийн 28.8-д дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхын саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүддээ хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно. Дэд хорооны даргын бүрэн эрхийн хугацаа 1 жил байх ба

түүнийг улируулан сонгож болно. Дэд хорооны даргыг дэд хорооны гишүүдийн дотроос нэр дэвшүүлж, Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар сонгоно гэсэн байгаа.

Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо хуралдаад санал нэгтэйгээр тус дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурийн нэрийг дэвшүүлсэн. Энэ дээр өөр саналтай гишүүн байна уу? Пүрэвдорж гишүүн өөр санал гаргах гэж байна. Хүн нэр дэвшүүлэх гэж байна. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ иргэдийн яриад байдаг хар машин гэж ярьдаг сонгуулийн санал тоолох машины асуудлыг би ярих гээд байна. Тэгэхээр 2012 онд би Их Хуралд нэр дэвшиж ялагдаж байхдаа энэ сонгуулийн хар машинд итгэж байсан, 2016, 2020 онд би ялж байхдаа ч итгэж байсан. 2012 онд Монгол Ардын намынхан ялагдчихаад сонгуулийн хар машиныг талбай дээр шатааж байсан тохиолдол байгаа. Тэгээд манай намынхан ч гэсэн 16 онд ялагдчихаад бас энэ хар машин руу буруу чихдэг ийм зүйл байгаад байдаг юм. Тэгэхээр өнөөдөр 2020 оны Их Хурлын сонгуулийн 50 хувийг гараар тоолсон. Тэндээс 1 ширхэг ч зөрөө гараагүй. 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийг 100 хувь тоолсон. Тэндээс 1 ширхэг ч зөрөө гараагүй. Тэнд, жишээ нь манай Зэрэг сум дээр тооллоо гэхэд тэнд энэ зөрөө гарлаа, энэ будилаантай юм байна шүү гээд надад хэлнэ ээ дээ, хүмүүст хэлнэ ээ дээ, бусад хүмүүст хэлнэ ээ дээ. Гэтэл тийм юм байхгүй. Тэнд чинь бас ингээд л 2 намын төлөөллүүд бүгдээрээ л ороод сууж байгаа. Зарим 330 сумын чинь бараг 150 дээр нь Ардчилсан намын нөхөд засаглаж байгаа. Түүн дээр 1 ширхэг ч асуудал гарсан гэж ярихгүй байгаа. Тийм учраас ер нь бол энэ сонгуулийн хар машин гэдэг бол программ хангамж энэ тэрийг нь бүрэн шийдвэрлэх тэр хөрөнгө мөнгийг нь энэ оны төсвийн

тодотголоор бүрэн тавьсан байж байгаа.

Дээрээс нь энэ жил ч гэсэн бас төсвийн энэ жил төсөв дээр ч гэсэн бас 24 оны төсөв дээр бас хөрөнгө оруулалт энэ тэрийг нь бас нэмж тавьж байгаа. Тэгээд өнгөрсөн жилийн тэр төсвийн тодотгол дээр энэ жилийн 7 сард, 6 сард хэлэлцсэн төсвийн тодотголоор энэ сонгогчдын бүртгэлтэй холбоотой, өөрөөр хэлбэл Иргэний бүртгэлийн ерөнхий газрын хурууны хээний тоног төхөөрөмжийн машины бүрэн мөнгийг бас тавьж бүгдийг нь шинэчилж байгаа. Тэгээд ингээд ер нь бол их хэмжээний бас хөрөнгө оруулалтыг тавьж байна. Гол асуудал бол энэ сонгогчдын нэрсийн жагсаалт дээр ямар асуудал байна вэ гэвэл яах вэ, Ховд аймагт Зэрэг сумд ч байдаг юм уу, тийм ээ, аль эсвэл Дорнодын Дашбалбар сумд тэндхийн хүмүүс нэгнийгээ мэддэг учраас хэн орж ирээд дахин санал өгч байна гэдгийг мэдэж байгаа. Хэн танихгүй хүн орж ирээд санал өгч байгааг мэдэж байгаа. Тийм учраас орон нутагт бол энэ сонгогчдын нэрсийн жагсаалтын асуудал бол гайгүй түвшинд байдаг.

Тэгэхээр Улаанбаатар хотод энэ олон сонголтлоос гав ганцхан хүн гарч ирнэ гэдэг бол дээрээс нь тэр нь маш тийм сайн хяналт тавьдаг. Тэр БГД дээр нэг хүн гарч ирсэн болохоос биш бусад газар дээр бол энэ сонгогчдын хурууны хээний бүртгэлийн асуудал эргэлзээтэй байж магадгүй. Өөрөөр хэлбэл нэг бүлэг нөхөд тэр Сонгинохайрханы бүх одоо юу юу байдаг юм, хэсгийн санал хураалтын хэсэг дээр очоод ингээд царцаа маягаар яваад Ардын намыг сонгоод байсан байж магадгүй болчихоод байгаа байхгүй юу даа.

Тийм учраас манай Батсуурь даргын хувьд бол яг энэ орон нутагт олон жил ажилласан, сонгууль бас олон жил хийсэн, орон нутгийн туршилагатай ийм нөхөр байгаа. Тэгээд дээрээс нь Улаанбаатар хот дахь л тэр янз янзын

асуудлуудыг нэлээн сайн зөвлөгөө аваад, нэлээн сайн нухацтай ажиллаж, энэ талаар бас сайн хяналт тавихгүй бол бас болохгүй юм байна. Энэ дээр чинь бас одоо энэ 24 оны сонгуулиар ийм айхтар Ардын нам руу савах юм энэ бол цэвэр сонгуулийн тэр луйвартай холбоотой л гэж ойлгож болно. Тийм учраас хүмүүс яг энэ нь бэлэн болчихоод байна. Ийм бэлэн болчихоод байна. Тийм учраас энэ дээр бол аль аль нам нь, энэ өнөөдөр, ялангуяа эрх барьж байгаа намынхан, Хууль зүйн яам, түүний харьяа Иргэний бүртгэлийн ерөнхий газар энэ дээр бол маш тийм хариуцлагатай ажиллахгүй бол дараа нь энэ сонгуульд буруу тоолох энэ үйл явц, сонгууль дээр гарч байгаа ялангуяа бүртгэлийн луйврын асуудал нэлээн тийм асуудал руу дөхүүлж магадгүй шүү. Тийм учраас сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлд хяналт тавих дэд хороо маш сайн хариуцлагатай ажиллах ийм зайлшгүй шаардлага гарч байна.

Манай болон бусад нөхөд нэлээн мэдлэг, мэдээлэлтэй тэр хүмүүс байгаа. Тэр хүмүүсээс зөвлөгөө авч энэ дэд хороо бол идэвхтэй ажиллах зайлшгүй шаардлага гарчхаж байна гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа.

Дэд хорооны даргад нэр дэвшүүлэх ажил дууслаа. Жамбын Батсуурь гишүүнийг нэр дэвшүүлсэн. Нэр дэвшигчээс асуух хүн байна уу. Байхгүй байна. Үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Сая Пүрэвдорж гишүүний хэлсэнтэй санал нэг байна. Үнэхээр сүүлийн сонгуулиудыг бүр зориуд хуульд өөрчлөлт оруулаад 100 хувь гараар тоолж хянадаг болсон. Үнэхээр хаана ч ямар ч зөрөө гараагүй. Тэгэхээр энэ машинтай холбоотой

асуудал бол байхгүй гэдэг нь ойлгомжтой. Бүгдээрээ хүлээн зөвшөөрч байгаа.

Бүртгэлтэй холбоотой асуудал дээр ч гэсэн харьцангуй гайгүй болов уу гэж бодож байна. Хуучин бол иргэний бүртгэл, сонгогчийн бүртгэл 2 тусдаа байдаг байсан, тийм ээ. Одоо бол ерөөсөө 1 л яг иргэний бүртгэл хаана байна, тэр хүн тэндээ сонгогч байна уу гэдгээр нь ингэж бүртгэдэг болсон. Тэгэхээр нөгөө царцаа энэ тэрийн асуудал үндсэндээ байх боломжгүй болсон. Тэгээд нөгөө биеийн өгөгдөхүүнээр таньдаг ийм тоног төхөөрөмж юмнууд энэ боломжийг хааж байгаа гэж хэлж болохоор байна.

Санал хураалт явуулъя. Ер нь энэ Төсвийн зарлагын хяналтын дэд хороо энэ Сонгогчийн нэрсийн жагсаалт бүртгэлийн хяналтын дэд хороог хуульчилж зориуд цөөнхийн зүгээс даргаар нь тавьж, хяналтыг сайжруулах ийм зохицуулалт оруулсан байгаа гэдгийг бас хэлчихье.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Жамба овогтой Батсуурийг Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргаар сонгох нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Тогтоолын төсөл танилцуулъя. 11 гишүүн санал хураалтад орж, 9 гишүүн дэмжиж, 81,8 хувиар Жамбын Батсуурь гишүүн Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргаар сонгогдож байна.

Тогтоолын төсөл танилцуулъя. Дэд хорооны даргыг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8, 28.9 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Төрийн

байгуулалтын байнгын хорооноос
тогтоох нь:

*Монгол Улсын Их Хурлын гишүүн
Жамбын Батсуурийг Сонгогчийн нэрсийн
жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд
хорооны даргаар сонгосугай.*

*2 дахь заалт нэмж оруулах
шаардлага байна уу? Автоматаар явчих
байх.*

*Батсуурь гишүүндээ ажилд нь
амжилт хүсье. Үнэхээр хариуцлагатай
дэд хороо. Сонгуулийн үр дүн хүлээн
зөвшөөрөгдөх, цаашидаа Монголын
төрийн легитим байдал хүлээн
зөвшөөрөхөд маш том, маш чухал үүрэг
гүйцэтгэх ийм Байнгын хороо байгаа юм.
Дэд хороо байгаа.*

17.41 цаг

*Өнөөдөр Байнгын хороогоор
хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан
хаасныг мэдэгдье.*

Гишүүддээ баярлалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ